

А. М. ПОЗДНЕЕВ МОНГОЛД ХИЙСЭН ХОЁР ДАХЬ АЯЛАЛЫН ҮЕЭРЭЭ (1892-1893) ОЧИЖ ҮЗСЭН ХҮРЭЭ ХИЙДҮҮД*

Тэлэки Кристина¹

Доктор

Оросын нэрт эрдэмтэн Алексей Матвеевич Позднеевын (1851-1920) зохиолууд² нь Манжийн хожуу үеийн Монгол орны буддын шашин, засаг захиргаа, арилжаа наймаа болон тухайн үеийн монголчуудын аж амьдрал, нийгэм соёлын талаарх хамгийн үнэт гадаад сурвалж болох юм. Позднеев нь Монголд хоёр удаа урт хугацааны аялал 1878-1879 онд болон 1892-1893 онд хийсэн. Түүний судалгаанаас Манжийн үеийн засаг захиргаа ба арилжаа наймааны гол төв болох Их хүрээ, Ховд, Улаистай хотуудын болон Монгол орны Орос, Хятад улстай хил залгагдах газрын өртөө, аян жин, олон сүм хийд, хүрээ болон өртөө дугануудын талаар бидэнд дэлгэрэнгүй сурвалж үлдсэн. Позднеевын бас нэг номонд³ Монголын Буддын шашны онцлогуудыг дэлгэрэнгүй харуулсан байдаг. Үндээ хүрээ хийдийн зохион байгуулалт, барилга ба дуганы доторх эд хогшил, лам нарын сахил санваар, хэргэм тушаал, хийдийн тэргүүн, хувилгаадын аж амьдрал, лам нарын здэлж хэрэглэж байсан хувцас, хийдүүдийн хурал, дүйцэн өдруүд болон даяанч нарын бясалгал гэх мэтчилэн сэдвүүдийг хамарсан байдаг. Гэхдээ Позднеевын хамгийн зузаан “Монгол улс ба Монголчууд”⁴ хэмээх хоёр боть нь түүний Монголд болон Хятадад хийсэн аялалын үедээ (1892-1893) бичсан аян замын тэмдэглэл шинжтэй бүтээл юм. Энэ нь XIX зууны эцэс XX дугаар зууны эхэн үеийн Монголын байдлыг судалж мэдэхэд нэн

* Тухай өгүүлэлийн уг эх нь анх 2014 онд англи хэлээр гарсан: Teleki, K. Monastic Sites visited by A. M. Pozdneev during his Second Trip to Mongolia (1892-1893). *Acta Orientalia Academiae Scientiarum Hung.* Vol. 67 (3), 337-361. Budapest 2014. www.akademiai.com/doi/abs/10.1556/AOrient.67.2014.3.7?journalCode=062, www.real.mtak.hu/23763.

¹ Доктор (PhD), эрдэм шинжилгээний ажилтан, Өтвөш Лоранд Их Сургууль, Монгол Судлалын Төв, Будапешт хот.

² Позднеев, А. М., Города северной Монголии Санкт-Петербург 1887, 1980 (дахин хэвлэгдсэн); Позднеев, А. М., Монголия и Монголи. Т. 1-2. Санкт-Петербург 1896, 1898; Позднеев, А. М., Монгольская летопись “Эрдэнийн эрихэ” с пояснениями, заключающими в себе материалы по истории Халхи 1636-1736. Санкт-Петербург, 1883; Позднеев, А. М., Очерки быта буддийских монастырей и буддийского духовенства в Монголии, Санкт-Петербург 1887, 1993 (дахин хэвлэгдсэн.); Позднеев, А. М., Ургинские хутухты. Исторический очерк их прошлого и современного быта. *Travaux de la Troisième Session du Congrès International des Orientalistes*. Санкт-Петербург 1880, 1980 (дахин хэвлэгдсэн); Позднеев, А. М. (эмхт.), *Boysa jibüündamba qutuuty-yn Erdeni juu-du jalarraysan tuyuji*. Монгольская Крестоматия. Санкт-Петербург 1900; Pozdneev, A.M., Religion and Ritual in Society: Lamaist Buddhism in late 19th-century Mongolia. ed.: Krueger, J.R. The Mongolia Society. Bloomington 1978; Pozdneev, A. M., Mongolia and the Mongols, edited by Krueger, J. R., translated by Shaw, J. R. and Plank, D., Bloomington, Indiana University 1971.

³ Позднеев, А. М., Очерки быта буддийских монастырей и буддийского духовенства в Монголии, Санкт-Петербург 1887, 1993 (дахин хэвлэгдсэн.); Pozdneev, A.M., Religion and Ritual in Society: Lamaist Buddhism in late 19th-century Mongolia. ed.: Krueger, J.R. The Mongolia Society. Bloomington 1978 (цаашид Ritual). Монгол хэлээр Янжинсүрэн, С., Монгол судлаач Позднеевын тухай цөөн уг. Лам нарын сэтгүүл 1. Улаанбаатар 2010, 175-177-р х.; Гантуяа, М., Шашны ёслол буюу хурал ном. Лам нарын сэтгүүл 1. Улаанбаатар 2010, 178-183-р х.

⁴ Позднеев, А. М., Монголия и Монголи. Т. 1-2. Санкт-Петербург 1896, 1898; Pozdneev, A. M., Mongolia and the Mongols, edited by Krueger, J. R., translated by Shaw, J. R. and Plank, D., Bloomington, Indiana University 1971 (цаашид Mongolia).

дэхөмтэй, маш дэлгэрэнгүй сурвалж бичиг болох юм. Нөгөөтэйгүүр энэ бүтээл шиг Монголын тухайн үеийн байдлыг монголоор бичсэн сурвалж бичгүүд цөөхөн байгаа⁵ бөгөөд зохиолд гарах ихэнх сүм хийдийн талаар ямар ч сурвалж үлдээгүй учраас Позднеевын бичсэн энэ ном нь Монголд 1937 оноос хойш одоо бүүр сураггүй устсан хүрээ хийдүүдийн тухай түүхэн сурвалжуудыг хадгалан үлдсэн Буддын шашны нэгэн чухал бүтээл болох билээ.

1990 оноос хойш Монголд монголчуудын түүхийг судлах нь их чухал болсон. Буддын шашин нь XVII зуунаас Монгол соёлын хагацашгүй хэсэг болох учраас Манжийн үеийн хүрээ хийдүүдийн тухай мөн олон ном хэвлэгдэн гарсан.⁶ 2007 онд Монголын Урлагийн Зөвлөл ба Гандантэгчэнлийн хийдийн хамтран гаргасан "Монголын сүм хийдийн түүхэн товчоо" гэдэг төсөл бий.⁷ Уг төслийн дагуу Монгол даяар зургаан баг гарч урьд үеийн ба орчин үеийн сүм хийдүүдийн байршилыг тогтоох, тэмдэглэж үлдэх аянд гарсан. Мөн хуучин сүм хийдийн тухай аман түүхийн бичлэг цуглуулсан. Д.Майдар⁸ ба Б.Ринченгийн сүм хийдийн жагсаалтын дагуу⁹ гаргасан төслийн дагуу хуучин сүм хийдүүдийн түйрыг олж тэмдэглэн аваад 1937 оноос өмнө Монгол даяар мянгаас илүү сүм хийдүүд байсныг тодорхойлсон. Уг судалгаанд хэрэглэсэн арга барилаар гурван сарын хугацаатай судалгааны ажлаар¹⁰ 2010 онд би өөрийн биеээр Позднеевын 1892-1893 онд Монголд үзэж судласан сүм хийдүүдийн одоогийн байдал, дахин сэргээсэн эсэхийг судлахаар болсон юм. Энэ нь "А. М. Позднеевын 100 жилийн өмнө очиж үзсэн Монголын сүм хийдүүдийн соёлын өв" хэмээх төсөл бөгөөд үүнийг Англи улсын Шинжлэх Ухааны Академын "Stein-Arnold Exploration Fund" сан ивээн тэтгэсэн (SA100018). Судалгааны гол зорилго нь Позднеев номондоо дурдаж байсан 47 сүм хийдийн одоогийн байдлыг тэмдэглэх болон судалгаанд бэлэн байгаа сурвалжуудыг олж тодруулах (архивын материал, орчин үеийн ном, өндөр настай лам нарын яриа гэх мэт), мөн түүнчлэн тэдгээр сүм хийдээс үлдэж хоцорсон бурхан шүтээнийг судалж, хийдийн гэрэл зураг, өөр батлах баримт үлдсэн эсэхийг, мөн сүм хийдийн байршилыг тодруулж, томоохон хийдүүдийг дахин сэргээсэн эсэх талаар, орчин үеийн холбогдох үйл ажиллагааг судлахад орших юм.¹¹

Төслийн анхны шат бол Позднеевын "Монгол улс ба Монголчууд" хэмээх номын тэмдэглэлүүдийг дэлгэрэнгүй судлах байсан юм. Манжийн үеийн сүм хийдүүдийг судлахад Манжийн үеийн түүх, засаг захиргааны тухай судалж мэдэх нь нэн хэрэгтэй байв. Тэр үеийн Халхын 4 аймаг бол олон хошуунд хуваагдаж, хошуу ноёны (хан,

⁵ Сономдагва, С., Манжийн захиргаанд байсан үеийн ар монголын засаг захиргааны зохион байгуулалт (1691-1911), Улаанбаатар 1961.

⁶ Цэдэндамба, С. — Лхагва, Л. — Сонинбаяр, Ш. — Лувсанбалдан, Э. — Отгонбаатар, Р. — Амгалан, Н. (эмхт). Монголын сүм хийдийн түүхэн товчоон. Улаанбаатар 2009; Эрдэнэбилэг, Б. (эд.), Монголын сүм хийдийн түүхээс... Улаанбаатар 2012.

⁷ www.mongoliantemples.org.

⁸ Майдар, Д., Монголын хот тосгоны гурван зураг. Улаанбаатар 1970.

⁹ Ринчен, Б., Монгол ард улсын угсаатны судлал, хэлний шинжклэлийн атлас. Улаанбаатар 1979.

¹⁰ Уг судлагааны хүрээнд Дундговь, Өвөрхангай аймаг ба Төв аймгийн урд хэсэгт Majer Zsuzsa ба Teleki Krisztina 150 хуучин, 40 орчин үеийн сүм хийдүүдийг тэмдэглэсэн. www.mongoliantemples.org-r эзэн уу! Mön Majer Zs., Teleki K., On the Current Condition of 190 Old and Present-Day Monastic Sites in the Mongolian Countryside, Zentralasiatische Studien 39. Bonn 2011, pp. 93-140.; Teleki K., Building on ruins, memories and persistence: Revival and survival of Buddhism in the countryside, In: Silk Road 7, Seattle 2009, pp. 64-73. http://www.silkroadfoundation.org/newsletter/vol7/srjournal_v7.pdf; Majer Zs., Monasteries in the Mongolian Landscape Once and Today. ESCAS XI Conference 2009, Studying Central Asia: On Quest for the New Paths and Concepts? CD publication. Central European University. Budapest 2009.

¹¹ Судалгааны дэлгэрэнгүй үр дүн удахгүй DVD-гээр гарна.

ван, гүн, бэйл, бэйс, засаг) хошуу хүрээ нь хамгийн чухал, хамгийн том шашны төв байжээ. Мөн хошуудаас гадна шавь нутаг гэж нэрлэгдсэн дахин хувилгаан дүрээ олсон тамгатай хутагтуудын газар ч бас байсан байна.

Одоогоор „сүм хийд” гэхээр, „Гандан” гэж нэрлэгдэж Буддын шашны төв гэж ойлгох болсон. Харин „сүм дуган” гэхээр (Тө. 'du-khang) ерөнхийдөө Ариун газар гэж ойлгож Буддын шашинд голчлон хэрэглэх бол “сүм” гэвэл илүү өргөн утгаар ашиглаж Христийн сүм, Лалын сүм гэж нэрлэх болжээ. „Хурал”-ыг нь шашны ёслол хурал гэж ойлгоно. Хүрээ ганз гэж зарим дахин сэргээсэн хүрээ хийдүүдийн нэрийн дотор гардаг (Зүүн хүрээ Дашчойлин хийд, Заяын хүрээ Төгс баясгалант буян дэлгэрүүлэх хийд, гэх мэт). Харин 1937 оноос өмнө нэг хүрээ нь олон сүмээс, 500-2000 гаруй ламаас, борчууд, хамжлагат ардын гэрүүдээр хүрээллүүлсэн байсан бол, нэг хийд нь олон сүмээс, 50-500 гаруй ламаас бүрдэж байсан ба сүм бол арваад ламтай; дуган, хурал, жас бол нэг газарт буюу гэрт цөөхөн лам нарын цөөхөн шүтээнтэй хурал хурдаг газар байлаа. Нэг өртөө нь нөгөөгөөсөө 30 орчим километр зайдай оршиж байсан ба өртөөнүүдэд ойрхон өртөө хурал буюу өртөө жас бас байжээ. Ойрхон оршиж байсан сүм хийдүүд нь ихэнхдээ өөр хоорондоо холбоотой байсан (нэг хошуу буюу нэг тамгатай хутагтын нутагт байсан сүм хийдүүд) ба лам нар зарим хурлаа цуг хурж, нэг дацанд сурж байжээ. Хошууны доторх хошуу хүрээ нь хамгийн их, бусад нь арай цөөхөн ламтай байжээ. Хүрээ хийддээ амьдардаг лам нар ч байсан мөн хөдөө гэр бүлтэйгээ амьдарч зөвхөн дүйцэн өдөр буюу тогтмол хурлуудаар сүм хийдэд ирдэг байсан лам нар ч бас байжээ.

Хурлын газрууд янз бүр байсан болохоор хүрээ, хийд, сүм гэж ялгаж нэрлэхэд зарим талаар зөрчилтэй, будлиантай юм. Тэгээл Позднеевын судлагаа хурлын газруудыг ялгаж нэрлэхэд их дөхөм болж байгаа билээ. Ийм учраас энэ өгүүллэгт Позднеевын 2 дахь аялалын гол зорилгыг тодруулж, очиж үзсэн сүм хийдүүдээс гадна түүний олж тогтоосон хурлын газруудыг одоо монгол хэлээр танилцуулахыг зорьсон. Ийнхүү Манжийн хожуу үеийн хурлын газруудыг тодруулсанаар Монголд одоо бүрмөсөн устсан хүрээ хийдүүдийн эх зураг, хэрхэн харагдаж, ямар байсныг олон талаас нь мэдэхийн хамт, тухайн хийд ямар төрөлд багтаж байсныг бас тодруулж болох юм. Өгүүллэгийн эцэст энэ түүхийн газруудаас одоо юу үлдсэндэйг товчхон танилцуулна.¹²

Позднеевын аялалын гол зорилго

Позднеев анхны аялалынхаа үеэр Оросын Хиагтаас ирж хойт зүгийн өртөө замаар Их хүрээнд ирсэн. Дараа нь Улиастай, Ховд хот руу явсан. Замдаа Их хүрээ, Эрдэнэ Зуу, Ооромбо гэгээний хийд (Архангай, Өгийнуур сум) гэх мэтчилэн сүм хийдүүдийн аж амьдралыг судалжээ.

Хоёр дахь аялалын үеэр (1892-1893) Хиагтаас ирж засаг захиргааны гурван гол төв Их хүрээ, Улиастай ба Ховдыг дахин судлахаар ирсэн. Ялангуяа баруун өмнөд өртөө замаар явсан. Мөн алдар нэртэй хутагт хувилгаан, тайж ноёны хошуу хүрээг үзэж 200-300 жилийн түүхтэй хүрээ хийдүүдийг судласан бөгөөд замд таарсан жижиг сүм, өртөө хурлуудыг бас судласан.

Позднеевын аялалын гол зорилгын нэг нь Манжийн засаг захиргаа, Хятадын

¹² Уг судалгааг Англи улсын Шинжлэх Ухааны Академын "Stein-Arnold Exploration Fund" сан (SA100018) ба Унгар улсын OTKA PD 83465 ивээн тэтгэсэн. Хутагт хувилгаад ба тэдний хэрэг хийддийн цаашид судлагааг Унгар улсын Bolyai János Kutatási Ösztöndíj ивээн тэтгэсэн. Монгол хэлний талыг хянахад тусалсан Жамъянсүрэнгийн Нарантуяа болон өгүүллэгт гарах хотуудын хятад нэрийг тодорхойлоход тусалсан Балог Маатиаш нарт талархал илэрхийлье!

арилжаа, наймааг судлах, тухайн хошууны засаг захиргаа, хүрээ хийдийн лам нарын амьдрал, шашин шүтлэгийг тодруулахад байжээ.

Мөн энэ удаад анхны аялалын үеэр үзсэн Их хүрээ, Улиастай, Ховд хотуудыг дахин очиж үзэж, Сайр ус ба Улиастайг холбох их өртөө замаар явах бас зорилготой байсан. Өртөө бол Монголд 13-дугаар зуунд албанаар бүтээгдсэн, элч нарын хурдан зам байсан. Элч нар тэнд хонож бас хурдан морь сэлгэх боломжтой байжээ. Позднеевын үед нэг өртөө 30 километр орчим зайдтай байсан ба Монголын хамгийн чухал засаг захиргаа, арилжаа наймааны төвүүд болох Орос, Хятадтай холбох гол зам байжээ. Позднеевын бичсэнээр “гол өртөө замуудын нэг болох их өртөө зам нь Улиастайгаас Бат Хaalга (Хятадын нэг хот) хүрдэг байв. Зам зуур Сайр ус өртөөг дайрна. Сайр ус бол Өргөөгөөс Бат Хaalга хүрэх замд таарна. Улиастайгаас Хиагт шууд орох бол бага өртөө замаар явах ба ойролцоогоор 40-50 хоног болно” (Mongolia, 1-р боть, 181-р х.).

Позднеевын аялалын нөгөө зорилго нь Монголын нэр алдар бүхий хүрээ хийдүүдийг үзэх явдал байв. 1892 онд Хиагт/Алтанбулагаас Монголд оронгоо, эхлээд Их хүрээнд очсон. Энэ удаа өмнө нь очсон өртөөгөөр биш, харин оросын хилд ойрхон орших Цэ засгийн хошуу хүрээ, Буриад сүсэгтэн олны мергөлийн газар болох Амарбаясгалант хийдийг судлангаа Их хүрээ оржээ. Их хүрээнээс гарч байсан Буухиа өртөө замд таарах өмнө зүгийн Сайр ус түүний анхаарлыг их татсан. Учир нь энэ зам Хиагт-Өргөө-Бат Хaalга болон Ховд-Улиастай-Бат Хaalтыг холбох жин замын өртөө байжээ. Позднеев Сайр уснаас гарч Баруун зүтг 35 Харчин өртөө зам ба 20 Халх өртөө замаар явж Улиастайд хүрсэн. Тэндээс баруун өртөөгөөр Оросын хилд ойрхон орших Ховдод хүрсэн. Замаараа Дуутын хүрээ, Яруугийн хүрээг очиж үзсэн. Замаасаа арай хол байсан учраас Ламын гэгээний хүрээнд харамсалтай очиж үзээгүй аж (odoogийн Баянхонгор аймаг, Эрдэнэцогт сум). Буцахдаа Ховдоос Улиастай ирж, олон давааг даваад Ялгуусан хутагт, Хамба хутагт, Далай ван, Заяын хүрээнд очсон. Их хүрээнд хүрэх замдаа Эрдэнэ Зуу, Баруун хүрээнд очиж үзсэн. Их хүрээнээс зүүн өмнө зүгийн замаар Зүүн Чойрыг гаталж Өвөр Монгол Хятадад хүрсэн. (Энэ өгүүллэгт Өвөр Монголын аялалын сүм хийдүүд орохгүй.) 1893 онд Монгол улсын орчин үеийн нутагт дахин ирж Егүзэр хутагтын хүрээ, Сэцэн ханы хүрээг гаталж Их хүрээнд дахин хүрсэн. Орос буцахдаа зүүн зүгийн Хэрлэнгийн Зүүн хүрээ, Буриадуудын шүтэж байсан Хүүхэн хутагтын хүрээнд очиж үзэж Орос руу гарсан.

Дээр дурдсан сүм хийдүүдийг шалгаж үзвэл Позднеев нь Монголын их алдартай түүхтэй олон хийдүүдээр зочилжээ. Зарим нь Оросын хязгаар (Цэ засгийн хошуу хүрээ, Хүүхэн хутагтын хүрээ), зарим нь эртний түүхтэй бөгөөд Өндөр гэгээн Занабазартай (1635-1723) холбоотой түүхийн газрууд мөн (Эрдэнэ Зуу, Баруун хүрээ, Зүүн хүрээ, Амарбаясгалант хийд, Дамбадаржaa хийд). Хутагт хувилгаадын хүрээ хийд (Ялгуусан гэгээний хүрээ, Хамба хутагтын хүрээ, Заяын хүрээ, Егүзэр хутагтын хүрээ, Хүүхэн хутагтын хүрээ) ба хошуу ноёдын хийдүүдэд (Далай вангийн хүрээ, Сэцэн ханы хүрээ) бас зочилсон. Бусад сүм хийдүүдийн ихэнх нь зүгээр Позднеевын аялалын зам зуур таарсан учраас очиж үзэх нь боломжтой байсан бөгөөд¹³ иймээс бидэнд зөвхөн томоохон хүрээ хийдүүд ч биш, жижиг цөөхөн лам хуврагтай сүм хийдүүдийн тухай сурвалж үлджээ (жишээ нь өртөө хурлууд). Номондоо сүм хийдүүдийн тухай бичсэн аялалын тэмдэглэлээс гадна түүний авсан фото зургууд ч түүхийн баримт мөн. Учир нь зурган дээрх сүм хийдийн ихэнхийг нураасан

¹³ Одоогийн байгаа замууд хуучин замтай адилхан байна. Жишээ нь галт тэрэгний зам ч хуучин өртөөний зам юм.

бөгөөд өнөөдөр харамсалтай нь туйр л үлджээ. Позднеевын орос хэлээр бичсэн уг номонд (Монгол улс ба Монголчууд) түүний харсан 47 хүрээ хийдүүдийн 15-ны зураг орсон.¹⁴ Бусад зураг ба тэмдэглэлүүд одоо Санкт-Петербург хотын Газар зүйн Нийгэмлэгт хадгалагдаж байх боломжтой. Мөн Позднеев нь зарим сүм хийдүүдийн гэрэлт хөшөөнд бичигдсэн түүх (жишээ нь Ховдын Шар сүм, Дамбадаржаа хийд), хэдхэн нярав нарын данс нугалбаруудыг судласан учраас олон нандин, одоо байхгүй байгаа баримтыг ч үлдээсэн.¹⁵ Позднеевын замын тэмдэглэлд түүний сонирхон харсан зүйлүүдийн тухай мөн судласан зүйлүүд ч орсон. Аянд явах замдаа хүмүүстэй танилцан, ярилцангaa Монголын олон зам, өртөө, аян жин, арилжаа, Монголчуудын зан заншил, соёл, орос хятад хүмүүс, тэднээс замд ойр байсан том хүрээ хийдүүдийн тухай ч мэдээлэл олж авсан учраас бид түүний үзээгүй харин сонссон хүрээ хийдүүдийн тухай ч энэ номноос унших боломжтой билээ (жишээлбэл Мянгад хүрээ, Дөрвөд вангийн хүрээ).¹⁶

Позднеевын явсан зам ба нийт цаг хугацаа

Позднеев нь 1892-1893 он хүртэл бараг нэг жил гаруй аялжээ. Хиагтаас Их хүрээ хүртэл хоёр долоо хоног явсан (1892 оны 6-р сарын 27-аас 7-р сарын 9 хүртэл). Түүний аялсан нутаг нь одоогийн Сэлэнгэ, Төв аймгийн газар нутаг. Оросоос ирээд эхлээд Буурын харуулын дуганыг үзсэн. Орхон голыг гатлаад Сэлэнгэ мөрний эрэгт орших Цэ Засгийн хүрээ дараа нь Эрдэнэ вангийн хүрээнд хүрсэн. Ханхарын хошуунд Хятадын суурингийн ойрхон нэг дуганг харж Амарбаясгалант хийдэд хүрсэн. Тэндээс Тариачны сүмийн хавьд Орхон голд одоогийн Орхон гүүрний ойрхон гатласан.

Их хүрээнд ирж хоёр долоо хоног (6-р сарын 9-өөс 7-р сарын 24 хүртэл) Оросын консулын дэнжид байхдаа Хүрээний амьдралтай танилцжээ. Түүний харж тэмдэглэсэн зүйлс нь Их хүрээний сүм дуган, хэсгүүдийн хамгийн дэлгэрэнгүй сурвалж юм.¹⁷

Их хүрээнээс өртөө замаар Улиастай хүртэл 2 долоо хоног гаран явсан (7-р сарын 24 – 8-р сарын 11 хүртэл (?)). Зам нь одоогийн Төв, Дундговь, Өвөрхангай, Баянхонгор, Завхан аймгаар явсан. Их хүрээнээс өмнө зүг руу явах 14 Буухиа өртөөгөөр явсан (Позднеевын бичсэнээр Сонсголон буюу Босог өртөө, Бүхэг буюу Баясгалант, Долоон буюу Амгалант, Жаргалант, Өндер даваа, Тал булаг, Наран буюу Нарийн, Модон, Тойром, Баянхошуу, Сүж). Сайр уснаас (Далдолоон) баруун зүг руу Харчин өртөө замаар явж (Модон, Шувуут, Луус, Жирэм, Мэнгэт буюу Дам шагшуурга, Цавчир, Төгрөг буюу Дам хашаат, Зээрэн, Онги, Үнэгт, Хадат), 20 Халх өртөө замаар (Хар нүдэн, Гарид, Тац, Худаг урд, Шаргалжуут, Түйн, Уртын хар толгой, Олгой, Уут, Байдраг, Заг, Ховол, (Улаан) Бумба, Өвөр Жаргалант, Ар Жаргалант, Хужирт, Дааган дэл, Төмөрт, Шурга, Хуа широот) явж Улиастайн хавьд Агтын сүм, Манжийн эзэн хааны хөрөнгөөр барьсан Дуутын хүрээнд хүрсэн.

Позднеев Улиастайд 10 хоног байсан (8-р сарын 11–21). Манжийн сангийн хот

¹⁴ Амарбаясгалант хийд (1-р боть. 3, 4), Их хүрээ (6-22), Сайр усны өртөө (22), Зээрэнгийн өртөө (23), Улиастай (36-41), Ховд (42-43), Ялгусан хутагтын хүрээ (48), Далай вангийн хүрээ (49), Заяын хүрээ (52-53), Эрдэнэ Зуу (54-57), Баруун хүрээ (58), Хөгнө тарниийн хийд (59), Дамбадаржаа (61), Егузэр хутагтын хүрээ (2-р боть. 51), Хэрлэнгийн Зүүн хүрээ (52-55).

¹⁵ Үндэсний Түүхийн Архив нь зарим хүрээ хийдүүдтэй холбоотой баримтыг хадгалж байна.

¹⁶ Позднеевын номонд бага сага буруу ташаа ойлголт байдаг. Жишээлбэл Халх Зая бандидыг Ойрдын Зая бандидтай сольсон байдаг (1-р боть, 271-272-р х.).

¹⁷ Их хүрээний сүм хийдүүдийн тухай www.mongoliantemples.org/English, Teleki, K., Monasteries and Temples of Bogdiiin Khüree. Ulaanbaatar 2012 үзнэ үү.

ба Хятадын Маймаачэнгийн үйл явдлуудын талаар дэлгэрэнгүй бичсэн. Монгол сүм хийдүүд Улиастайд байгаагүй. Позднеевын анхны аялалын дараа буюу 1870-аад оны үед хотоны (Дунган, хуй хуй) дайралтаас хойш өөрчлөлт орсон.

Улиастайгаас тав хоногийн дотор Ховдод хүрсэн (8-р сарын 21–25 (?). Улиастайгаас гарч Өвгөн хүрээг (Яруугийн хүрээ) судлаж өртөө замаар явжээ (Алдар, Борх (?), Худаг улаан, Их зэс (?), Бага зэс (?), Зүр хүзүү, Буга (?); Аргалант, Бага нуур, Дөргөн нуур, Харгана, Жаргалант, Зах булаг, Хар ус).

Ховдод долоо хонохдоо (8-р сарын 25 – 9-р сарын 4 (?)) Манжийн Сангийн хот, Маймаачэн, хятадын нийлээд сүмийг судласан. Ховдод ойрхон Манжийн эзэн ханы ивээн тэтгэсэн Шар сүмийг бас Позднеев судласан.

Ховдоос Их хүрээнд буцахдаа өртөөгөөр биш харин нилээд удаан хүрээ хийдүүдтэй танилцахаар сар хагас явжээ (9-р сарын 4 – 10-р сарын 17). Одоогийн Ховд, Завхан, Архангай, Өвөрхангай, Булган, Төв аймгуудаар явжээ. Ховдоос эхлээд Хар ус нуурын хойт эргээр хэцүү элстэй замаар Улиастайд дахин ирж, Улиастайгаас гарахдаа 1870-аад онд Хотонуудын дайнаар ирсэн Солон цэргүүдийн Гэсэрийн сүмийг харжээ. Дараа нь Ялгусан хутагтын хүрээ ба Хамба гэгээний хүрээнд зочилсон. Загастын давааг даваад Загастын дуган ба Ялгусан хутагтын хоёр гэрийг харж, жинхэн хот шиг Далай вангийн хүрээнд ирсэн (Тариатын хүрээ). Зүүнөмнөд зүгт оршиж байсан Арцатын сүмийг замдаа судлаж Цагаан давааг даваж Зая гэгээний хүрээнд ирж түүхийг дэлгэрэнгүй судласан. Цаашдаа явж Цагаан сүм дэх хүрээг холоос харж, Орхон голын дэргэдэх Зуугийн ламын сүм, ба Эрдэнэ Зууд хүрсэн. Тэндээс Баруун хүрээнд очоод Хөгнө Тарни хийд руу яваад Их хүрээнд хүрсэн.

Их хүрээнд 4 долоо хоног үлдэж (10-р сарын 17-ноос 11-р сарын 12 хүртэл) Хятад руу аялахдаа бэлтгэсэн. Мөн Дамбадаржaa хийдийг судласан. Их хүрээнээс гарч Бэйжин хүрэхээр (11-р сарын 12 – 12-р сарын 5) анх Туулын гүүр гатлаж Модчины сүмд очиж үзсэн. Адуучны сүмийг харж Зүүн Чойр хүрсэн. Хилийн өмнө Дээрс булангын сүмийг үзсэн. Тухай аялал нь одоогийн Төв, Дорноговь, Говь-Сүмбэр, Дорноговь аймгуудаар явсан.

Өвөр Монгол ба Хятадад Бэйжин, Бат Хaalга (Zhangjiakou), Хөххот (Guizhou Cheng), Chengde fu / Jehol, Долнуур, Бяруу хотын замаар явч 1893 онд Ар Монголд дахин ирж, замаараа одоогийн Сүхбаатар, Хэнтий, Төв аймгуудын Егүзэр хутагтын хүрээ (6-р сарын 14), Өндөр Майдарын хийд, Сэцэн ханы хүрээ, Хурц ламын хийд, Зараа зүлэгтийн сүмийг тэмдэглэсэн байна. Хэрлэн голыг гатлаж Их хүрээнд ирж 6-р сарын 27-ноос 7-р сарын 12 хүртэл үлджээ.


Их хүрээнээс Орос руу явахдаа одоогийн Төв ба Хэнтий аймгийн Хэрлэнгийн Зүүн Хүрээ, Хүүхэн хутагтын хүрээ мөн Далаат сүмээр очжээ. Улхан харуулаас Оросын хилд 6-р сарын 26-нд хүржээ.

Позднеевын тэмдэглэсэн хүрээ хийдүүд

Их хүрээг нэг гэж тооцвол, Позднеев 47 ийм түүхэн газрыг тэмдэглэсэн байна. Доор сүм хийдүүдийн нэrsийг олон сурвалжаас олж цуглувансыг,¹⁸ GPS-д орсон, аймаг хошуудын урьд хэрэглэж байсан болон аймаг сумдын одоогийн газар нутгийн нэrsийг (О. Пүрэвийн хараахан хэвлэгээгүй газрын зургийн дагуу), хурлын газруудыг болон Позднеевын очсон үзсэн он сар өдер, номондоо дурдсан хуудасны

¹⁸ Ринчен, Б., Монгол ард улсын угсаатны судлал, хэлний шинжлэлийн атлас. Улаанбаатар 1979; Цэдэндамба, С., Лхагва, Л., Сонинбаяр, Ш., Лувсанбалдан, Э., Отгонбаатар, Р., Амгалан, Н. (эмхт.). Монголын сүм хийдийн түүхэн товчоон. Улаанбаатар 2009

дугаарын хамт үзэж болно. 1930-аад оны хэлмэгдүүлэлтийн дараа 47 түүхэн газрын дотроос үлдсэн дуганууд бол Амарбаясгалант, Их хүрээ, Заян хүрээ, Эрдэнэ Зуу, Баруун хүрээ, Дамбадаржаа. Зарим томоохон түүхэн газрууд нь тусгаар тогтолын дараа дахин сэргээгдсэн. Доорх жагсаалтанд одоогийн байдлын талаар бас товч тэмдэглэсэн нь бий.



Зураг 1. Позднеевийн аялал Монгол улсын газрын зураг дээр (Ринчен 1979)

1. Буурын харуулын хурал / Буурын хурал / Гандандашилин дуган (Тө. dga'-Idan bkrashis gling) / Дэчинчойнхорлин (Тө. bde-chen chos-'khor gling). GPS: Хойт $50^{\circ}15.646'$, Зүүн $106^{\circ}23.917'$. Түшээт хан аймаг, Буур харуул; Сэлэнгэ аймаг, Алтанбулаг сум. Харуулын хурал. Танилцуулга: 1892 оны 6 сарын 27, 1-р боть, 4-р х. Одоогийн байдал: туйр.
2. Цэ засгийн хошуу хүрээ / Эрдэнэ вангийн хүрээ / Эрдэнэ вангийн хошуу хүрээ / Хотол чуулганы хүрээ / Баруун хийд / Ганданчойнхорлин (Тө. dga'-Idan chos-'khor gling). GPS: X $49^{\circ}55.791'$, З $105^{\circ}26.396'$. Түшээт хан аймаг, Цэ засгийн хошуу - Эрдэнэ вангийн хошуу, Сэлэнгэ аймаг, Цагааннуур сум. Хошуу хүрээ. Танилцуулга: 1892 оны 6-р сарын 30, 1-р боть, 9-14-р х. Одоогийн байдал: туйр.
3. Ханхарын хошууны дуган. GPS: ≈ X $49^{\circ}41.324'$, З $105^{\circ}15.775'$. Түшээт хан аймаг, Цэ засгийн хошуу - Эрдэнэ вангийн хошуу; Сэлэнгэ аймаг, Зүүнбүрэн/Баруунбүрэн/Хушаат сум (?). Дуган. Танилцуулга: 1892 оны 7-р сарын 1, 1-р боть, 15-р х. Одоогийн байдал: олдохгүй.
4. Амарбаясгалант хийд / Өндөр гэгээний хийд. GPS: X $49^{\circ}28.785'$, З $105^{\circ}05.120'$. Түшээт хан аймаг, Эрдэнэ вангийн хошуу (Их шавь); Сэлэнгэ аймаг, Баруунбүрэн сум. Хийд (Манж эзэн ханы байгуулсан хийд). Танилцуулга: 1892 оны 7-р сарын 2, 1-р боть, 16-32-р х. Одоогийн байдал: үлдсэн дуганууд, туйр, дахин сэргээсэн.
5. Тариачны сум. GPS: ≈ X $49^{\circ}13.593'$, З $105^{\circ}15.086'$. Түшээт хан аймаг, Эрдэнэ вангийн хошуу / Зоригт вангийн хошуу / Ахай бэйсийн хошуу (?) Их шавийн отог); Сэлэнгэ аймаг, Баруунбүрэн/Сант/Орхон сум (?). Сүм. Танилцуулга: 1892 оны 7-р сарын 5, 1-р боть, 34-р х. Одоогийн байдал: олдохгүй.
6. Их хүрээ / Өргөө / Ривогэжигандашдуулчин (Тө. ri-bo dge-rgyas dga'-Idan bshad-sgrub gling) / Даа хүрээ / Богдын Хүрээ / Хутагтын Хүрээ / Нийслэл Хүрээ / Арын Хүрээ / Номын Их Хүрээ. GPS: X $47^{\circ}55.583'$, З $106^{\circ}55.030'$. Түшээт хан аймаг, Их хүрээ; Улаанбаатар. Амбас, Маймаачэн, Оросын консулын дэнж, Богд жэзвүндамба хутагты хүрээ. Танилцуулга: 1892 оны 7-р сарын 9, 1-р боть, 42-95-р х. Одоогийн байдал: үлдсэн дуганууд, дахин сэргээсэн.

7. Бүхэг өртөөний хурал / Бүхэг өртөөний дуган / Баясгалант өртөө. GPS: ≈ X 47°38.259', 3 106°43. 470'. Түшээт хан аймаг, Дархан чин вангийн хошуу; Төв аймаг, Сэргэлэн сум (?). Буухиа өртөө хурал. Танилцуулга: 1892 оны 7-р сарын 24, 1-р боть, 99-р х. Одоогийн байдал: одлохгүй.
8. Долоон өртөөний хурал / Долоон өртөөний дуган / Амгалант өртөө. GPS: ≈ X 47°31.141', 3 106°43.413'. Түшээт хан аймаг, Дархан чин вангийн хошуу; Төв аймаг, Сэргэлэн сум (?). Буухиа өртөө хурал. Танилцуулга: 1892 оны 7-р сарын 25, 1-р боть, 99-100-р х. Одоогийн байдал: одлохгүй.
9. Жаргалант өртөө хурал / Жаргалант өртөөний дуган. Түшээт хан аймаг, Дархан чин вангийн хошуу; Төв аймаг, Сэргэлэн сум (?). Буухиа өртөө хурал. Танилцуулга: 1892 оны 7-р сарын 26, 1-р боть, 101-р х. Одоогийн байдал: судалгаагүй.
10. Тал булгын өртөө хурал / Тал булгын өртөөний дуган. Түшээт хан аймаг, Дайчин бэйсийн хошуу; Төв аймаг, Баянцагаан сум. Буухиа өртөө хурал. Танилцуулга: 1892 оны 7-р сарын 26, 1-р боть, 105-р х. Одоогийн байдал: судалгаагүй.
11. Сайр усны өртөө сүм (Гэсэр сүм ба Ганданпунцаглин, Тө. dga'-ldan phun-tshogs gling). GPS: X 44°40.164', 3 106°59.688'. Түшээт хан аймаг, Дайчин бэйсийн хошуу; Дундговь аймаг, Өлзийт сум. Харчин өртөө хурал. Танилцуулга: 1892 оны 7-р сарын 28, 1-р боть, 112-117-р х. Одоогийн байдал: туйр.
12. Цагаан хадны сүм / Цагаан сүм. GPS: X 44°57.614', 3 106°22.003'. Түшээт хан аймаг, Түшээт чин вангийн хошуу; Дундговь аймаг, Өлзийт сум. Харчин өртөө сүм. Танилцуулга: 1892 оны 7-р сарын 30, 1-р боть, 118-р х. Одоогийн байдал: туйр.
13. Мэнгэтийн хийд / Мэнгэтийн хурал. GPS: X 45°25.869', 3 105°05.979'. Түшээт хан аймаг, Түшээт чин вангийн хошуу; Дундговь аймаг, Хулд сум. Харчин өртөө хийд. Танилцуулга: 1892 оны 7-р сарын 31, 1-р боть, 121-122-р х. Одоогийн байдал: туйр.
14. Зээрэнгийн хийд / Зээрэн өртөө сүм. GPS: X 45°49.447', 3 103°54.753'. Сайн ноён хан аймаг, Илдэн бэйлийн хошуу; Өвөрхангай аймаг, Сант сум. Харчин өртөө сүм. 1892 оны 8-р сарын 1, 1-р боть, 124-126-р х. Одоогийн байдал: туйр.
15. Хадат өртөөний сүм / Хадатын өртөө хурал / Хадатын хүрээ / Баруун хурал / Улаан ламын хийд / Улан ламын хийд. GPS: X 46°00.860', 3 102°39.270'. Сайн ноён хан аймаг, Үйзэн вангийн хошуу; Өвөрхангай аймаг, Тарарт сум. Харчин өртөө сүм. Танилцуулга: 1892 оны 8-р сарын 2, 1-р боть, 127-128-р х. Одоогийн байдал: туйр, шинэ дуган.
16. Өвөржаргалантын хурал / Өвөржаргалант хийд. Сайн ноён хан аймаг, Жонон гүний хошуу; Баянхонгор аймаг, Гурванбулаг сум. Халх өртөө хийд. Танилцуулга: 1892 оны 8-р сарын 24, 1-р боть, 144-р х. Одоогийн байдал: судалгаагүй.
17. Агытын сүм / Агытын хийд / Агытын хүрээ / Агытын хийд / Рашилин (Тө. bkra-shis gling). GPS: X 47°30.027', 3 096°49.212'. Засагт хан аймаг, Хошууч мэргэн бэйсийн хошуу; Завхан аймаг, Цагаанхайрхан сум. Сүм. Танилцуулга: 1892 оны 8-р сарын 10, 1-р боть, 152-р х. Одоогийн байдал: туйр, шинэ дуган (цагийн хуралтай).
18. Дуутын хүрээ / Наян дуутын хүрээ / Сайн итгэмжит сүм / Гандандэччин (Тө. dga'-ldan bde chen gling). GPS: X 47°30.925', 3 096°54.494'. Засагт хан аймаг, Хошууч мэргэн бэйсийн хошуу; Завхан аймаг, Цагаанхайрхан сум. Хүрээ, Манж эзэн хааны ивээн тэтгэсэн. Танилцуулга: 1892 оны 8-р сарын 10, 1-р боть, 152-155-р х. Одоогийн байдал: туйр.
19. Улиастайн хятадын сүмүүд: Гэсэр сүм, Манзшир сүм, Цагаан Дарь эхийн сүм, Аюушийн сүм, Эрлиг хааны сүм, Дарь эхийн сүм, гэх мэт. GPS: X 47°44.821', 3 096°52.199'. Засагт хан аймаг, Улиастай; Завхан аймаг, Улиастай. Жанжин, Сангийн хот, Маймаачэн, Монголын жас. Танилцуулга: 1892 оны 8-р сарын 11-21, 1-р боть, 155-182-р х. Одоогийн байдал: туйр, шинэ Монгол хийдүүд.
20. Яруугийн хүрээ / Өвгөн хүрээ / Дашпунцоглин (Тө. bkra-shis phun-tshogs gling). GPS: X 47°42.002, 3 096°37.105'. Засагт хан аймаг, Их шавь; Завхан аймаг, Алдархаан сум. Хүрээ. Танилцуулга: 1892 оны 8-р сарын 21, 1-р боть, 184-185-р х. Одоогийн байдал: туйр, дахин сэргээсэн дуган Улиастай руу нүүжээ.

21. Ховдын хятадын сүмүүд: Гэсэр сүм, Лалын сүм, Цагаан өвгөний сүм (?), Усан сүм, Эрлиг хааны сүм, Тай ван миао. GPS: X 48°00.761', 3 091°38.582'. Ховд; Ховд аймаг, Ховд. Манж сайд/амбан, Сангийн хот, Маймаачэн, Монголын жас. Танилцуулга: 1892 оны 8-р сарын 25-аас 9-р сарын 4 (?), 1892, 1-р боть, 198-222-р х. Одоогийн байдал: туйр. Шинэ Лалын сүм.
22. Шар сүм / Ховдын Шар сүм / Өлөлдийн Шар сүм / Өлөлдийн Түгээмэл амаржуулагч. GPS: X 48°01.315', 3 091°36.927'. Ховдын хязгаар, Өлөлдийн Үйзэн гүнгийн хошуу; Ховд аймаг, Ховд сум. Сүм. Танилцуулга: 1-р боть, 214-222-р х. Одоогийн байдал: туйр, Ховдод хийдийг сэргээн шинээр засварлаж байна.
23. Улиастай дахь Солонуудын Гэсэр сүм. GPS: ≈ 47°47.131, 096°53.314. Засагт хан аймаг, Улиастайгаас хойно. Завхан аймаг, Яруу сум. Сүм. Танилцуулга: 1892 оны 9-р сарын 21, 1-р боть, 244-р х. Одоогийн байдал: олдохгүй.
24. Ялгуусан хутагтын хүрээ / Ялгуусан гэгээний хүрээ / Засагт хан аймгийн Ялгуусан хутагтын хийд / Идрийн хүрээ / Ялгуусан хутагтын хийд / Холдсоныг тогтоогч / Ганданчойжилин (Тө. dga'-Idan chos-kyi (?) gling) / Гандантэгчэнлин (Тө. dga'-Idan theg-chen gling). GPS: X 48°07.127', 3 097°29.070'. Засагт хан аймаг, Ялгуусан хутагтын шавь; Завхан аймаг, Идэр сум. Тамгатай хутагтын хүрээ. Танилцуулга: 1892 оны 9-р сарын 24, 1-р боть, 247-255-р х. Одоогийн байдал: гэрэлт хөшөө, Идэр сум дахь шинээр барьсан дуган.
25. Хамбын хүрээ / Хамбын гэгээний хүрээ / Арын хүрээ / Гандандаржаалин (Тө. dga'-Idan dar-rgyas gling) / Дашиганданлин (Тө. bkra-shis dga'-Idan gling) / Буянбаясгалант. GPS: X 48°15.530', 3 97°34.857'. Сайн ноён хан аймаг, Хамба гэгээний шавь; Завхан аймаг, Идэр сум. Тамгатай хутагтын хүрээ. Танилцуулга: 1892 оны 9-р сарын 25, 1-р боть, 255-256-р х. Одоогийн байдал: туйр.
26. Загастын дуган / Загастайн дуган / Загастын хийд. GPS: X 48°04.352', 3 098°51.381'. Сайн ноён хан аймаг, Далай Чойнхор вангийн хошуу; Архангай аймаг, Цахир сум. Дуган. Танилцуулга: 1892 оны 9-р сарын 28, 1-р боть, 260-261-р х. Одоогийн байдал: туйр.
27. Далай вангийн хүрээ / Тариатын хүрээ / Далай Чойнхор вангийн хүрээ / Тариатын Дээд хүрээ / Далай Чойнхор вангийн Баруун хүрээ / Үүрд хөгжүүлэгч хийд / Тариатын Доод хүрээ / Тариатын Зүүн хүрээ / Далай Чойнхор вангийн Зүүн хүрээ / Сайнаар судлагч хийд / Санчүвлин (Тө. bzang chub gling). GPS: X 48°22.036', 3 099° 40.183'. Сайн ноён хан аймаг, Далай чойнхор вангийн хошуу; Архангай аймаг, Тариат сум. Хошуу хүрээ. Танилцуулга: 1892 оны 9-р сарын 27, 1-р боть, 261-266-р х. Одоогийн байдал: туйр, сэргээсэн дуган нь сумын төв рүү нүүсэн.
28. Арцатын хийд / Арцатын хурал. GPS: ≈ N 47°32.773', E 101°20.850'. Сайн ноён хан аймаг, Сайд вангийн хошуу; Архангай аймаг, Их Тамир сум. Хийд. Танилцуулга: 1892 оны 10-р сарын 4, 1-р боть, 271-р х.. Одоогийн байдал: туйр.
29. Заяын хүрээ / Зая гэгээний хүрээ / Заяын Дээд хүрээ (Буяныг дэлгэрүүлэгч / Гандангэжээлин / Тө. dga'-Idan dge rgyas gling), Доод хүрээ (Өлзийг бадруулагч). GPS: X 47°28.503', 3 101°27.049'. Сайн ноён хан аймаг, Зая гэгээний шавь; Архангай аймаг, Цэцэрлэг. Тамгатай хутагтын хүрээ. Танилцуулга: 1892 оны 10-р сарын 4, 270-277-р х. Одоогийн байдал: улдсэн дуганууд, туйр, дахин сэргээсэн.
30. Цагаан сүмийн хүрээ / Зоригт гүнгийн хүрээ / Гомбо гүнгийн хүрээ / Сантын хүрээ. GPS: X 47°04.414', 3 102°04.793'. Сайн ноён хан аймаг, Зоригт гүнгийн хошуу. Архангай аймаг, Хотонт сум. Танилцуулга: 1892 оны 10-р сарын 7, 1-р боть, 280-р х.. Хошуу хүрээ. Одоогийн байдал: туйр.
31. Хувилгаан Дагвадаржаагийн сүм / Зуугийн ламын сүм / Зуугийн хувилгаан ламын сүм / Зуугийн хувилгааны хийд / Зуугийн сүм / Ёнзор ламын хийд. GPS: X 47°12.409', 3 102°47.789'. Түшээт хан аймаг, Түшээт ханы хошуу; Өвөрхангай аймаг, Хархорин. Сүм. Танилцуулга: 1892 оны 10-р сарын 8, 1-р боть, 281-р х. Одоогийн байдал: туйр.
32. Эрдэнэ Зуу / Эрдэнэ Зуу хийд / Бат Эрдэнэ Зуу. GPS: X 47°12.137', 3 102°050.598'. Түшээт хан аймаг, Түшээт ханы хошуу (Их шавь); Өвөрхангай аймаг, Хархорин.

- Хийд. Танилцуулга: 1892 оны 10-р сарын 8, 1-р боть, 281-302-р х. Одоогийн байдал: үлдсэн дуганууд, туйр, дахин сэргээсэн.
33. Баруун хүрээ / Рибогэжиганданшадувлин (Тө. ri-bo dge-rgyas dga'-Idan bshad sgrub gling) / Түшээт ханы хүрээ / Шанхын хүрээ / Өндөр богдын өвгөн хүрээ. GPS: X 47°03.058', 3 102°57.258'. Түшээт хан аймаг, Түшээт ханы хошуу хүрээ (Их шавь); Өвөрхангай аймаг, Хархорин сум, Шанх баг. Хошуу хүрээ. Танилцуулга: 1892 оны 10-р сарын 10, 1-р боть, 302-304-р х. Одоогийн байдал: үлдсэн дуганууд, туйр, дахин сэргээсэн.
34. Хөгнө тарны хийд / Дамчойжанчүүлин (Тө. dam chos byang-chub gling) / Хөгнө тарнын өвгөн хийд / Хөгнө тарны хүрээ. GPS: X 47°42.498', 3 103°69.323'. Түшээт хан аймаг, Үйзэн гүнгийн хошуу; Булган аймаг, Рашиант сум. Хийд. Танилцуулга: 1892 оны 10-р сарын 12, 1-р боть, 307-р х. Одоогийн байдал: туйр, сэргээсэн дуганууд.
35. Дамбадаржаалин / Дамбадаржаа(гийн) хийд (Тө. bstan-pa dar-rgyas gling) / Шашныг бадруулагч хийд / Шажныг бадруулагч хийд. GPS: X 47°58.953', 3 106°56.263'. Түшээт хан аймаг, Дархан чин вангийн хошуу (Их шавь); Улаанбаатар. Хийд. Танилцуулга, 1892 оны 10 сарын 29, 1-р боть, 387-392-р х. Одоогийн байдал: үлдсэн дуганууд, туйр, дахин сэргээсэн.
36. Модчины сүм / Хөлийн модчины сүм / Баянзурхны дуган (?). GPS: ≈ X 47°52.753', 3 107°04.972'. Түшээт хан аймаг, Дархан чин вангийн хошуу; Улаанбаатар. Сүм. Танилцуулга: 1892 оны 11-р сарын 12, 1-р боть, 396--р х. Одоогийн байдал: олдохгүй.
37. Адуучны сүм. GPS: ≈ X 47°28.130', 3 107°20.651'. Түшээт хан аймаг, Дархан чин вангийн хошуу; Төв аймаг, Эрдэнэ сүм. Сүм. Танилцуулга: 1892 оны 11-р сарын 13, 1-р боть, 398-399-р х. Одоогийн байдал: олдохгүй.
38. Зүүн Чойр / Зүүн Чойрын хийд / Чойрын хийд / Чойрын хүрээ / Боржигны Зүүн Чойр / Боржигны Зүүн Жанжин Чойр хийд / Боржигин бэйлийн Зүүн Чойр / Зүүн Жанжин Чойр хийд / Чойдойчэнбобалданшигоманлин (Тө. chos-sde chen-po dpal-Idan bkra-shis sgo-mang gling). GPS: Н 46°12.967', Э 108°46.008'. Сэцэн хан аймаг, Боржигин Сэцэн вангийн хошуу; Говь-Сүмбэр аймаг, Сүмбэр сум. Хошуу хүрээ. Танилцуулга: 1892 оны 11-р сарын 18, 1-р боть, 408-411-р х. Одоогийн байдал: туйр, мөргөлийн сүм, Чойр хотод дахин сэргээсэн.
39. Дээр булагийн сүм/ Дээрсэн булагын сүм / Хондогын хийд. GPS: Н 45°16.937', Э 110°16.937'.¹⁹ Түшээт хан аймаг, Говь-мэргэн вангийн хошуу; Дорноговь аймаг, Алтанширээ сум. Сүм. Танилцуулга: 1892 оны 11-р сарын 23, 1-р боть, 420-р х. Одоогийн байдал: судалгаагүй.
40. Егүзэр хутагтын хийд / Егүзэрийн хийд / Эрдэнэ мэргэн бандидын хүрээ / Гүсэвдэчэн сүм (Тө. ? bde chen) / Өнө өглөйт. GPS: X 46°15.507', 3 114°36.336'. Сэцэн хан аймаг, Егүзэр хутагтын шавь; Сүхбаатар аймаг, Эрдэнэцагаан сум. Тамгатай хутагтын хийд. Танилцуулга: 1893 оны 6-р сарын 14, 2-р боть, 281-282-р х. Одоогийн байдал: үлдсэн байшингүүд, туйр, дахин сэргээсэн.
41. Өндөр Майдарын хийд. GPS: X 47°08.230', 3 112°25.376'. Сэцэн хан аймаг, Далай вангийн хошуу; Сүхбаатар аймаг, Мөнххан сум, Баянтэрэм баг. Хийд. Танилцуулга: 1893 оны 6-р сарын 19, 2-р боть, 287-р х. Одоогийн байдал: туйр, шинэ суварга.
42. Цэцэн ханы хүрээ / Сэцэн ханы хүрээ / Сэцэн ханы алтан жан өргөө / Өндөрхааны хүрээ / Шолой Цэцэн ханы хийд / Гүндгаравлин хийд (Тө. kun-tu dga'-bar gling). GPS: X 47°18.436', 3 110°39.022'. Цэцэн хан аймаг, Цэцэн ханы хошуу; Хэнтий аймаг, Өндөрхаан. Хошуу хүрээ. Танилцуулга: 1893 оны 6-р сарын 21, 2-р боть, 289-291-р х. Одоогийн байдал: үлдсэн байшингүүд, туйр, дахин сэргээсэн.
43. Хурц ламын сүм / Хурц ламын хийд / Хурц ламын суврага / Суврага хийд / Дашгэнпилин (Тө. bkra-shis dge 'phel gling). GPS: X 47°14.602', 3 110°35.127'. Сэцэн

¹⁹ Цэдэндамба, С., Лхагва, Л., Сонинбаяр, Ш., Лувсанбалдан, Э., Отгонбаатар, Р., Амгалан, Н. (эмхт.). Монголын сүм хийдийн түүхэн товчоон. Улаанбаатар 2009. 353-354-р х. Позднеев нэг л дуганыг дурдсан. Харин энэ номонд олон дугантай томоохон хүрээний тухай баримт байна. Энэ хоёр хийд адилхан болов уу.

- хан аймаг; Сэцэн ханы хошуу; Хэнтий аймаг, Мөрөн сум. Сүм. Танилцуулга: 1893 оны 6-р сарын 22, 2-р боть, 290-р х. Одоогийн байдал: туйр, шинэ суварга.
44. Зараа булангийн сүм / Зараа булангийн хийд / Их гачин отгийн хурал. Цэцэн хан аймаг, Ахай гүнгийн хошуу (?); Хэнтий аймаг, Дэлгэрхан сум. Сүм. Танилцуулга: 1893 оны 6-р сарын 24, 2-р боть, 294-295-р х. Одоогийн байдал: судалгаагүй.
45. Хэрлэнгийн Зүүн хүрээ / Зүүн хүрээ / Хэрлэн голын Зүүн хүрээ / Шаддувдаржаалин (Тө. bshad-sgrub dar rgyas gling)/ Шаддувчойнхорлын (Тө. bshad-sgrub chos-'khor gling) / Хөгшин хүрээ / Өвгөн хүрээ. GPS: X 48°00.831', 3 108°29.998'. Түшээт хан аймаг, Дархан чин вангийн хошуу (Их шавь); Төв аймаг, Мөнгөнморьт сум. Хүрээ. Танилцуулга: 1893 оны 7-р сарын 15-16, 2-р боть, 302-309-р х. Одоогийн байдал: туйр, Багануурт дахин сэргээгдсэн.
46. Хүүхэн хутагтын хийд / Хүүхэн хутагтын хүрээ / Өвөрбулангийн Хүүхэн хутагтын хүрээ / Ринчэнтэгчэнлин (Тө. rin-chen theg-chen gling), Дамчойжүрмэдлин/Дамчаажүрмэдлин (Тө. dam chos 'gyur-med gling). GPS: X 47°45.385', 3 109°35.738', X 47°45.863', 3 109°35.485'. Сэцэн хан аймаг, Мэргэн гүний хошуу; Хэнтий аймаг, Өмнөдэлгэр сум. Тамгатай хутагтын хүрээ. Танилцуулга: 1893 оны 7-р сарын 27, 2-р боть, 315-317-р х. Одоогийн байдал: туйр, шинэ суварга.
47. Далаат сүм / Далаад сүм? Далай бэйсийн хошуу; Хэнтий аймаг, Танилцуулга: 1893 оны 7-р сарын 24, 1-р боть, 320-322-р х. Одоогийн байдал: судалгаагүй.

Хурлын газруудын төрлүүд

Дээрх жагсаалтанд зарим нэг түүхэн газар бие биенээсээ өөрөөр нэрлэгдэж байгааг (жишээлбэл Чойрын хийд, Чойрын хүрээ) харуулахыг зорьсон юм. Хүрээ, хийд, сүм хэмээн хольж нэрлэх нь заримдаа өөр хоорондоо авцалдаагүй байдаг. Позднеевын бичсэнээр (Religion, 25-р х.) Монголд сүм хийдийн гурван тусдаа нэр байдаг байна. Үүнд: хүрээ, хийд ба сүм. Хүрээнд лам нар байнга амьдардаг бөгөөд тэдний гэр, хашаа байшигуд нь тухайн хүрээний төвд байрлах сүм дугануудыг тойроод оршдог байна. Сүм дээр лам амьдардаггүй, харин гэр бүлтэйгээ хөдөө байх ба зөвхөн тогтмол хурлуудын үеэр буюу дүйцэн өдрүүдээр сүм дээрээ ирж хурлаа хурдаг байжээ. Хийд нь уг ёсондоо бол даяанч нарын суух газар ажээ. Энэ нь борчууд, хамжлагат ардын амьдардаг газраас хол байрладаг байж. Позднеевын дурдсанаар уг хурлын газруудыг анх байгуулахдаа аль нэг нэрээр нь зөв нэрлэж байсан боловч түүний аялалын үеэр хүрээ, хийд, сүм гурвуудыг хольж хэрэглэх болсоныг ажиглажээ.

Анхан Позднеев хурал хурдаг газрын 4 төрлийг тодорхойлсон (Religion, 28-р х.). Үүнд Манжийн эзэн хааны зарлигийн дагуу Манжийн сангийн хөрөнгөөр байгуулагдсан сүм хийдүүд, голдуу ноёдуудын нэр алдартай хутагтуудад бариулсан сүм хийдүүд; хошуу ба хошуу сумдын сүм хийдүүд, хөрөнгө чинээтэй тойн буюу хувь хүмүүсийн бариулсан сүм хийдүүд. Позднеевын жагсаалтнаас өртөө харуулын хурлууд чухамдаа аль төрөлд орсон нь тодорхой биш байгаа учраас би хувьдаа үүнийг нэг төрөл болгон ялгаж гаргамаар байна. Мөн Позднеевын дурдсан хятад ба өөр харьяаны хүмүүсийн шашин шүтлэгийн газруудыг бас нэг төрөл болгож оруулмаар байна. Ийнхүү эдгээр 6 төрлийн хурлын газруудыг Позднеевын бичсэнээр буюу түүний үзэж харсан сүм хийдүүдийн жишээгээр доор танилцуульяа.

1. Хутагт хувилгаадын хүрээ хийдүүд

Позднеев номондоо Монголын хутагтуудын хоёр жагсаалт гаргажээ (Religion, 318-331-х.).²⁰ Хутагтууд нь Бурхан багшийг амьд байх үеээс хойш дахин төрлөө

²⁰ Хутагт хувилгаадын дотор нь 13 тамгатай хутагт ба 7 хутагтыг тустай дурдах хэрэгтэй. Лааган, Б., Халхын тамга бүхий хутагтуудын товчис. Улаанбаатар 2004; Дашбадрах, Д., Монголын хутагтуудын намтрын ойллого (XVII-XX зуун). Улаанбаатар 2004 номнуудыг үзнэ үү!

олсоор Энэтхэг, Төвд гээд дамжин дараа нь Монголд дахин төрсөн хувилгаад.²¹ Хүмүүсийн дунд олноо алдаршсан хутагт хувилгаад бол Монголын шарын шашны гол тэргүүлэгч нар байсан бөгөөд тэднийг хүмүүс билиг ухаан, ховорхон заяасан гоц авьяас, хийж буй үйлсээр нь буюу тэдний бичсэн төвд зохиолуудыг нь уншиж мэдсэнээр тэр хувилгаадын нэр их алдаршжээ. Зарим нэг нь Төвдөд сурч байгаад Монголдоо буцаж ирсэн. Мөн Төвдөөс ирсэн лам нарын хойт дүр нь Монголд төрсөн нь бий.²²

Позднеевын бичсэнээр (Religion, 34-р х.) хутагтуудын хүрээ хийдэд лам нар суурьшиж байсан бөгөөд хурлаа өдөр бүр хурдаг байжээ (Цогчин, Тө. tshogs chen). Сүсэгтэнүүд хандив өргөдөг байж. Позднеевын тэмдэглэсэнээр хутагтуудын хүрээ хийдүүд бол бусад төрлийн хүрээ хийдүүдээс илүү баян, илүү том байсан. Мөн тухайн сумийг бариулахад тусласан ноёдоос хийдийн аль нэг нэр хүнд бүхий тойнд зориулж өөрийнхөө нутгаас хэдэн өрх тусгаарлаж өгдөг байсан ба тэдгээр хүмүүсийг болон тэр газрыг нийтэд нь хутагтын шавь нар буюу шавийн нутаг гэж нэрлэдэг байжээ. Манжийн эзэн хааны зөвшөөрлийн дагуу томилогдсон хутагт хувилгаад нь хэрэв шавь нарын тоо 700-д хүрвэл тэд нарыг захирч байхын тулд өөрийн тамгатай болдог байжээ. Шавь нар нь хутагтуудад лам нарын „зэд пог” өгч мөн хүрээгээ цаашид улам өргөжүүлж, хөгжүүлж байхын тулд ивээн тэтгэх маягаар татвар төлөх хэрэгтэй болсон байна. Позднеевын бичсэнээр хутагтуудын хүрээ хийдүүд нь мал сүргийн тоогоороо хамгийн ихтэйд тооцогдож байсан (Religion, 31-р х.). Малааmallаж ёсгөх нь шавь нарын үүрэг байв. Позднеевын дурдсанаар хэрвээ нэг хятад наймаачинд 50-60 тэмээтэй жин хэрэг болвол хүрээ хийдээс хөлсөлдөг байжээ. Хэрвээ шавь нар өөрсдийн тэмээгээ жинд оруулмаар байсан бол хүрээ хийдэд татвар төлдөг байжээ.

Хүрээ хийдүүдийн орлогын нэг үүсвэр бол өртөө байсан. Өртөөг Халхын дөрвөн аймаг нь дан дангаараа зөвхөн өөрсдийн харьяаны газартай биш, харин нэг аймаг нь нөгөө 3 аймагт ч өртөөг хариуцаж ажиллуулж байжээ. Хэрэв зарим өртөө тухайн өөрийн харьяаны нутгаасаа хол байрлаж байвал тус газарт оршиж буй хүрээ хийдтэй гэрээ байгуулж тэдгээр хүрээ хийдүүд хариуцах болсон (Religion, 33-34-р х.). Өртөөг ажиллуулж байгаа сүм хийд нөгөө өртөө хүртэлх зайнаас хамаарч гүйлгээ орлогоо тооцдог байв.

Хутагтуудын хүрээ хийдүүд нь ламын тоо болон сүсэгтэний тоо олонтой байсан болохоор хятад худалдаачдыг их татдаг байжээ. Наймаа хийхийг хүссэн хятад иргэн нь хүрээ хийдтэй гэрээ байгуулдаг байв. Зарим томоохон хүрээ хийдүүд бол ялангуяа хошуу ноёдод шар цай гэгдэх дервэлжин цай буюу мөнгө зээлдэг байжээ (Religion, 34-р х. Ялангуяа Их хүрээний дацангууд), харин зарим хутагт хятад данжаадаас шар цай болон мөнгө зээлээр авдаг байсан байна. (жишээлбэл Заяын гэгээн. Mongolia, 1-р боть, 276-277-р х.). Хэрэв нилээд чинээлэг хутагт байвал өөрийн хүрээ хийдээс гадна өөр сүм хийдүүдийг байгуулж шарын шашныг цааш нь улам дэлгэрүүлж байв.²³ Хутагтын хүрээнүүд сүсэгтэн олны хувьд мэдээж хамгийн чухал мөргөлийн газрууд байжээ. Мөн соёл боловсролын нэг гол суурин төв болж байжээ.

Шавь нарын засаг захиргааг хариуцуулахаар шанзодвагаар тэргүүлсэн тусгай

²¹ Жишээлбэл Позднеев Богд Жавзандамба хутагт (Mongolia, 1-р боть, 321-222-р х.), ба Хүүхэн хутагтын (Mongolia, 2-р боть, 320-322-р х.) дүрүүдийг танилцуулна.

²² Төвд, Монгол ба Манж улсын тэр болон шашны харилцаа их сонирхолтой. Нэг л жишээг үзэвл Богд Жавзандамба хутагт бол түрүүн Энэтхэг, Төвдөд төрөөд дараа нь Монголд хоёр удаа төрж дахин төвд дүрээ олжээ.

²³ 1920-оод, 1930-аад оны үед хүрээ хийдүүд, хутагт хувилгаадын эд хөрөнгийг улс хурааж хутагт хувилгаадын ихэнхийг баривчилсан. Позднеевын тэмдэглэлүүд нь тухай үеийн Зөвлөлт засгийн улс төрийн албаны болон МАХН-ын ашиглаж байсан үндсэн сурвалж болж магадгүй.

яам буюу тамгийн газар бий болгосон. Шавь нарын нутаг нь хутагтын хүрээтэй ойрхон байрладаг байжээ. Шанзодва бол малын аж ахуйгаас гадна өөр бусад чухал үйл хэргүүдийг хариуцаж байсан ба Позднеев замдаа Заяын хүрээний шавь нарыг хариуцдаг байсан хүнтэй Ховд-Улиастай хавьцаа уулзаж ярилцжээ (Mongolia, 1-р боть, 238-р х.). Тэр хүн Заяын шавь байж байгаад оргосон нэг хүнийг олж нутаг руу нь буцаахаар Ховдод ирсэн тухайгаа ярьжээ. Богд Жавзандамба хутагт бол ганцхан Их хүрээний эргэн тойрон биш, Монгол даяар шавь нутагтай байсан (Их шавь). Их хүрээний Шавийн Яамыг Эрдэнэ Шанзодвын Яам хэмээн нэрлэдэг байжээ. Позднеевын очиж үзсэн хүрээ хийдүүдээс Амарбаясгалант хийд, Яруугийн хүрээ, Эрдэнэ Зуу, Баруун хүрээ, Дамбадаржаа хийд, Зүүн Хүрээ бөгөөд тэд шууд Богдоор захицуулсан Их шавийн хүрээ хийдүүд байсан юм. Үндэсний Түүхийн Архив Эрдэнэ Шанзодвын Яамны баримтуудыг бүрэн эхээр нь хадгалан авсан учраас Их шавийн хүрээ хийдүүдийн тухай бусад сүм хийдүүдийг бодвол илүү их баримт үлдсэн байна.

Хутагтуудын хүрээ хийдүүд нь тахилын сүм, хурлын сүмүүдээс гадна олон дацантай (Тө. grwa-tshang) байсан. Позднеевын бичсэнээр Манжийн хааны оролцоотойгоор нэrd гарсан тамгатай хутагтуудын хүрээ хийдүүдийн өмнө заавал улаан хайс байдаг байсан (Mongolia, 1-р боть, 254-р х.). Позднеев 2 дахь аялалдаа очиж үзсэн хүрээнүүдээс дурдвал Заяын хүрээ, Ялгуусан гэгээний хүрээ, Хамба гэгээний хүрээ, Егүзэр хутагтын хүрээ, Хүүхэн хутагтын хүрээ тамгатай хутагтуудын хүрээ мөн. Бүгд шавь нутагтай байсан. Хутагт нарын нэг үүрэг бол номлол, тамга бусад тэмдэгүүдийг (олбог, сүйх тэрэг гэх мэт) авахаар Бээжин дэх Манжийн хаантай уулзаж, тэдэнд бараалхах явдал байв (Religion, 351-357-р х.). Мөн Манжийн хаанд бэлэг барих шаардлагатай байв. Шинэ дуганыг бариулахын өмнө Манжийн эзэн хаанаас тэр дуганд нэр хайрлахыг гүйх бас нэг ёс байжээ. Хутагт нарын Бээжин орох аялалд зардал их гардаг байсан учраас шавь нарт хэцүү байдал их тулгарч. Мөн зээл авах хэрэгтэй болдог байжээ (жишээлбэл Заяын хүрээ, Mongolia, 1-р боть, 276-277-р х.). Хутагтуудын зарим нь хятадын тавилга, гоёл чимэглэлүүдийг их хэрэглэдэг байсан (жишээ нь Зая гэгээн, Ялгуусан гэгээн), зарим нь Манжийн хааны хүндэтгэлээр Гэсэрийг шүтэж эхлэсэн (Ялгуусан гэгээн). Хутагт нар ер нь хүрээндээ өөрийнхөө лавранд (Тө. bla-brang) амьдардаг байжээ.



Зураг 2. Позднеевийн 1892 онд авсан Заяын Доод Хүрээний зураг
(Pozdneev 1896, 420-р х.)

2. Манжийн хааны хөрөнгөөр баригдсан сүм хийдүүд

Позднеевын бичсэнээр Манжийн хааны зарлигийн дагуу буюу түүний хөрөнгөөр баригдсан хүрээ хийдүүд нь (Амарбаясгалант хийд, Дуутын хүрээ, Шар сүм, Дамбадаржаа хийд) ерөнхийдөө гурван хэсэгтэй (Mongolia, 1-р боть, 152-р х.). Гадаах хүрээлсэн хэрэм нь улаан тойпуугаар хийгдсэн ба хийдийн өмнө Цам буюу наадмын талбайтай байна. Уг хүрээ хийдүүд байгуулагдсан түүхийг монгол, төвд, хятад, манж 4 хэлээр бичигдсэн гэрэлт хөшөөг „Түүхийн сүм” нэртэй газарт байрлуулсан юм. Сүм хийдийн барилгаа эхлүүлэхийн өмнө Манжийн хаан лам нарын тоог тогтоож, дуган барих лам нарын сууцыг барих, тэднийг тэтгэж лам нарт өөрийн сангаасаа цалин олгосон байна. Сүүлд эдгээр сүм хийдүүд биеэ даан, өөрсдийн мал сүргийг өсгөж, өөрсдийн орлого зарлагатай болсон (Religion, 37-р х.). Позднеев Ховдын Шар сүмд очиходо лам нарын сууцуудыг бас харжээ (Religion, 41-р х.). Позднеевын тэмдэглэсэнээр эдгээр хүрээ хийдүүд хутагт нарын хүрээнүүдийг бодвол арай ядуувтар гэж тэмдэглэжээ. Манж, хятадын сүм хийд ба Манжийн хааны ивээн тэтгэсэн хийдүүд нь манж хэлээр бичигдсэн “эзний сүлд” ба амбан, тайж, лам нар ивээн тэтгэсэн гэдгийг харуулсан “pien-e”-тэй байдаг байна (Religion, 103-104-р х., Mongolia, 1-р боть, 153-154-р х.). Асар, дуган нь голдуу хятад барилгын хийц загвартай. Манжийн хааны бариулсан хийдүүдийн зарим нь (жишээ нь Амарбаясгалант, Дамбадаржаа) сүүлдээ Их шавийн хийдүүд болсон.



Зураг 3. Ховдын Шар сүмийн туурь. 2010

3. Хошуу хүрээ, Сумдын сүм хийдүүд

Позднеевын мэдэгдсэнээр тэр үед (1892-93) Монголын нутаг 86 хошуунд (Religion, 42-р х.) хуваагдаж байсан. Хошуу хүрээ хийдүүд бол хошуунаас тогтмол тэтгэлэг авдаггүй байсан. Харин засварын ажил, шинэ дуган барих ажил гарвал хошуу нутгийн харьяат хүн бүр үүнд туслах үүрэгтэй байв. Хошуу хүрээ бол хошуу ноёны амьдардаг газар бөгөөд түүний амьдардаг газар, яамтай ойрхон баригдсан учраас сүсэгтэнгүүд их очиж цагаан идээ, эд мал гээд олон зүйлийг хандивладаг

байсан учраас „жандаг” их олсон. Лам нарыг болон лам болох хүсэлтэй хүмүүсийг хошуунд данс гарган хөтлөдөг байв.²⁴

Позднеев хошууны доторх сумдын сүм хийдүүдийг дурдахдаа тэдгээр нь ихэвчлэн аглаг тал газарт 3-4 гэрээр тойруулсан жижиг сүм хийдүүд байсан гэж тэмдэглэжээ (Religion, 43-р х.). Заримдаа нэг л дугантай байжээ. Зохион байгуулалт муутайн улмаас анх байгуулагдахдаа хурал хураад дараа нь лам нараа хөдөө буцааж, сүм дээрээ жилийн дүйцэн өдөр буюу тогтмол хурлуудын үеэр ирж хурал хурдаг байжээ. Энд лам нар ямар ч цалин авдаггүй харин өөрсдийнхөө боломж хүчээр малаа маллаж амьдардаг байсан.

Хошуу хүрээнээс Позднеев нь Цэ засгийн хошуу хүрээ, Далай вангийн хошуу хүрээ, Баруун хүрээ, Цэцэн ханы хүрээнд очиж үзсэн. Хошуу ноёд өөрийнхөө хошууг захирахын хамт мөн Манжийн хаанд таашаагдах хэрэгтэй байжээ. Позднеев Цэ засгийн хошуу хүрээнд зочилсон тухайгаа (Mongolia, 1-р боть, 9-14-р х.) ийн тэмдэглэжээ: Цэ засаг (Цэрэндондов) 1891 оны 12-р сард өөд болов. Түүний 15 настай ач хүү нь (буюу зээ хүү) түүний дараагийн үе залгамжлах хунтайж болох нь тодорхой бөгөөд, үүнийг Манжийн хаан 1893 онд батлана гэсэн учраас Позднеев 1892 онд айлчлах үед уг хошуу шинэ нэрээрээ батлагдаагүй байсан байна.

Хошуу ноёд хошуу хүрээндээ өргөө буюу лаврантай байсан бөгөөд хамаатнуудын дотор тойн, хутагт ч байсан бололтой. Аймгүүд нь хошуудаас бий болсон. Хошуу ноёд аймгийн чуулганд оролцох хэрэгтэй байсан байна. Позднеев бол аймгийн хаадын хүрээ хийдүүдээс Цэцэн ханы хүрээ, Түшээт ханы хүрээг биенээрээ үзсэн байна.

4. Хувийн сүм хийдүүд

Позднеевын тэмдэглэснээр түүний айлчлалын үед хувийн сүм хийдүүд нь бараг хүнгүй байсан байна (Religion, 44-р х.). Тариачны сүм, Адуучны сүм, Хурц ламын хийд нь үүний жишээ болно. Тэдний лам хуврагийн тоо нь цөөхөн ажээ.

5. Өртөө ба Харуулын хурлуууд

Сайр усны өртөө бол Хиагт-Өргөө-Бат Хаалга-Бээжин хүрэх замыг Бат Хаалга-Улиастай замтай холбох нэг төв байсан. Позднеев Монгол орноор аялахдаа олон янзын өртөө замаар явсан учраас өртөө хурлуудын тухай баримт нилээд үлдсэн. Өртөөний байршил хэмжээ, тэнд судаг хүмүүс болон хөрөнгө мөнгөнэесөө хамаараад зарим өртөө нь гэрийн хуралтай зарим нь модон дугантай аль эсвэл сүм хийдтэй байсан байна. Хурлын газар нь Позднеевын бичсэнээр Буухиа өртөөнүүд замын Бүхэг, Долоон, Жаргалант, Тал булаг, Харчин өртөө замын Сайр ус, Мэнгэт, Зээрэн, Хадат, Халх өртөөний Өвөр Жаргалантад лав байсан. Уг түүхэн газруудын туйрыг судлахад Буухиа өртөө дуганудаас бараг юу ч үлдээгүй, ихэнх тохиолдолд хүмүүс яг оноож газрыг мэдэхгүй байсан зэрэг юм. 1920-оод оны өртөө зам бол Позднеевын явсан замнаас жаахан өөр ч болсон байж магадгүй. Харчин өртөө хурлуудын туйр нилээд үлдсэн. Говь нутаг учраас модон дуган гэхээсээ шавар буюу туйпуун дуганууд баригдсан байсан учраас туйр сайн үлджээ (Сайр ус, Мэнгэт, Зээрэн). Хүрээ хэмжээг нь үзвэл 1930-аад оны үед Мэнгэт, Зээрэн бол 50-100 лам хурал хурдаг газар байсан шинжтэй. Позднеевын явсан бусад өртөөний заримд нь (жишээлбэл Шувуут, Луус, Онги, Үнэгт) 1930-аад оны үед сүмтэй байсан нь тодорхой байна.²⁵ Эднийг Позднеев анзаарсангүй юу, энэ талаар сонсож мэдээгүй юу, аль

²⁴ Позднеевын тэмдэглэлийг үзнэ үү. (Religion, 174-175-р х.).

²⁵ www.mongoliantemples.org.

эсвэл 1892 оноос хойш баригдсан ч байж болох талтай. Позднеевын тэмдэглэнээр Халх өртөө нь Харчин өртөө нараас хэмжээ багатай байсан. Мөн эд нар өвөл зун нүүдэг байжээ. Жишээ нь Бат Хаалга-Улиастай өртөө Шурагаас (?) Заг хүртэл өвөлдөө өмнө зүг рүү 35-40 километр нүүдэг байсан гэнэ. Мөн Буухиа өртөөний суурийг (жишээ нь Бүхэг, Долоон) Позднеев тэмдэглэлдээ зам нь зундаа болон өвөлдөө жаахан ялгаатай байсан гэж бичжээ.

Позднеевын бичсэний дагуу өртөөнд хурал хурдаг лам нарын зарим нь цагийн хурлаа хурахаар ойрхон байдаг хүрээ хийдүүдээс ирсэн байдаг. Харин бусад лам нарын талаар тэд нар тухайн хошууны лам нар уу, аль эсвэл өртөөг хариуцагч аймаг, хошуу, хүрээ хийдээс ирсэн хүмүүс үү эсвэл өртөө улаач нарын хамаатнууд уу гэдэг нь тодорхой биш гэж бодож байна. Аль нь ч байсан байж магадгүй юм. Позднеевын бичсэнээр (Mongolia, 1-р боть. 191-p x.) Монголд олон удаа таарсанаар Буга (?) өртөөний гэрт Лувсан гэлэн гэдэг хүн өөрөөсөө гадна дөрвөн ах дүүтэйгээ амьдарч байжээ. Тэд нар нь өртөөг хариуцаж, тэр "улсын сангаасаа" цалингаа авдаг байсан байна.

Мөн оросын хил дээрх харуулуудын зарим нь (жишээ нь Зүүн цэрэг, Буур) хэдэн ламтай, тэндээ хурал хурдаг байжээ.

6. Манж, хятад, орос сүм дуганууд

Монголд цөөн тоогоор лалын болон христийн шашны мөн хятадын сүм дуганууд ч байжээ.²⁶ Голдуу гадаадын хүмүүс олноор амьдардаг газар болох Хиагт, Их Хүрээ, Улиастай, Ховдод буюу хөдөө амьдарч байгаа гадаадын хүмүүсийн амьдарч байгаа газарт ойрхон тааралддаг байжээ (жишээ нь Сайр ус). Хятадын сүмтэй Позднеев Сайр ус, Их хүрээ, Улиастай, Ховд хотод таарч байсан ба мөн Солонгуудын Гэсэр сүмийг, Их хүрээний хутагт тройцкын сүмийг (үнэн алдартны сүм) бас дурдсан.

Хятадын Маймаачэн (наймааны хот) Хиагт-Алтанбулаг, Их хүрээ, Ховд, Улиастайд байв. Хятадын пүүсүүд нь Маймаачэнгүүдээс гадна томоохон хүрээ хийдүүдэд ойрхон байрладаг байв (жишээ нь Заяын хүрээ). Бага сага Оросын пүүс, наймаачингүүд ч бас байсан. Аян жингийн замаар болон хaa нэг байрлах сүм хийдүүдээр ганц нэг хятад худалдаачин очиж өөрийн бараа болох торго, чисчүү, гурил, жимс, хувцас хунаар, чихэр, сам гэх мэтийг зарж борлуулаад оронд нь ноос ноллуур, малын болон ангийн арьсыг авдаг байжээ. Бараагаа шар цайгаар мөн мөнгөөр (янчаан) төлөх боломжтой байсан. Маймаачэн ба Манжийн Сангийн хотуудад (Улиастай, Ховд) Гэсэрийн сүм болон оршуулагын газрын ойрхон Эрлиг хааны сүм заавал байдаг байв. Мөн Төв-Азийн буюу Хятадын лалын шашинтанггуудын Лалын сүм нь Ховд, Их хүрээ, Оросын үнэн алдартны сүм нь Их хүрээний ойрхон болон Хиагтад бас байсан. Хятад лам нарыг монголчууд хөх малгайтан, лалын лам нарыг цагаан малгайтан гэж нэрлэдэг байжээ.

Хүрээ хийдийн аж амьдрал, эргэн тойронд

Позднеев номондоо хүрээ хийдийн аж амьдрал, лам нарын мяндаг тушаал, сахил санваар, хурлуудын тухай дэлгэрэнгүй бичсэн байдаг (Religion). Доор XIX зууны эцэст Монголын сүм хийдүүдийн аж амьдрал ямар байсныг Позднеевын ном болон 2010 онд хийсэн өөрийнхөө судалгааны ажил дээрээ тулгуурлан товчхон танилцуулъя.

Хүрээ хийдүүдийг анх үүсгэн бий болоход Манжийн хааны буюу Манжийн

²⁶ Ринченгийн 44-р газрын зургийг үзнэ үү!

Гадаад Харилцааны Яамны (Ли фан Юан) зөвшөөрөл хэрэгтэй болсон (Religion, 48-р х.) бөгөөд хийд байгуулах бусад дэг жаягийг Буддын шашны зан үйлс тогтоосон байсан учраас хүрээ хийдийг барих нь цогцолбор няйт ажил байжээ.

Туйр болон үлдсэн хүрээ хийдүүдийн байршилыг шалган үзвэл салхинаас жавраас сэргийлж голдуу уулын өвөрт баригдсан гэж элбэг тохиолддог. Бараг бүгд гэрээс дуган хүртэл урагшаа харуулсан, зүүн урагшаа харсан үүдтэй. Том хурлын газруудын төв болох Цогчин дуган ба өөр жижиг сүм дугануудтай байсан. Зарим нь хэрмийн дотор (Ярууний хүрээ, Манжийн сангаас байгуулсан хийдүүд), ихэнх нь задгай ил байдаг байсан. Лам нарын сууц нь хашаан доторх гэр эсвэл байшин, хэрэв Говьд бол хашаагүй эсвэл шавар хашаатай шавар байшиггууд байх жишээтэй.

Сүм хийдийг олон янзын нэрээр нэрлэдэг байв. Газрын нэрээр нь, төвд нэрээр нь, төвд нэрийн монгол орчуулгаар нь, хутагт, нэр алдартай лам, ноёны нэрээр нь, лам нарын тоогоор нь, голлох шүтээнээр нь хүртэл нэрлэдэг байжээ. Заримынх нь төвд нэрийг Манжийн хаан, Богд жавзандамба хутагт эсвэл өөр хутагт хувилгаад өгсөн байжээ.

Хэдхэн том хүрээ бол (жишээлбэл Ялгуусан гэгээний хүрээ, Далай вангийн хүрээ, Заяын хүрээ) хоёр хэсэгтэй (дээд, доод буюу зүүн, баруун) байв. Мөн том хүрээ хийдүүдэд суудаг лам нар нэгдэж аймаглаж байжээ (Амарбаясгалант, Эрдэнэ Зуу, Их хүрээ, Баруун хүрээ, Зүүн хүрээ, гэх мэт). Эд нарын ихэнх нь тухайн аймгийнхаа дугантай байсан бөгөөд бүх аймгийн лам нар нийлж Цогчин дуганд хурлаа хурдаг байжээ. Монголын сүм хийдүүдийн ихэнх нь төвд, хятад, монгол уран барилгын хийц загварыг хослуулан баригдсан байдаг. Позднеевын хамгийн анхан бусдаасаа ялгадах өөр хийц маягтай нь Ялгуусан гэгээний хүрээн дэхь Чойр дацан гэж бичжээ (Mongolia, 1-р боть, 253-р х.). Дуганууд нь мод, чулуу, тойпуу, шавараар баригдсан.²⁷

Монголд Шарын шашин нь хамгийн их дэлгэрсэн бөгөөд зарим улаан малгайтны (Сажаа, Нинма, Гаржид) сүм хийдүүд ч байсан. Позднеев бол улаан малгайтны хийдүүдээс Эрдэнэ Зуу (Сажа), Егүзэр хутагтын хийд ба Хүүхэн хутагтын хийдийд (Нинма ба Гаржид) очиж үзлээ.

Цогчин дуган буюу Гол дуганаас гадна бурхан бодисадва, сахиус нарын сүмүүд байсан бөгөөд том хүрээ хийдүүд нь дацангуудтай байв. Гүн ухааны Чойр (Тө. chos-grwa) буюу Цанид (Тө. mtshan-nyid) дацан лав байсан бөгөөд ихэнх нь домын дамжаа, гавжийн дамжаа (Тө. dka'-bcu'i dam-bca') барих боломжтой байсан. Мөн Манба/Мамба дацан (Тө. sman-pa grwa-tshang), Зурхай дацан (Тө. itsis-pa grwa-tshang), Жүд дацан (Тө. gryud-pa grwa-tshang) буюу Агва (Тө. sngags-pa), Ламрим дацан (Тө. lam-rim grwa-tshang) байсан. Цөөхөн том хийд нь аграмбийн дамжаа (Тө. sngags-rams-pa), маарамбийн дамжаа (Тө. sman-rams-pa) барихын боломжтой байсан. Позднеевын 2 дахь аялалын үеэр очиж үзсэн хийдүүдээс Цэ засгийн хошуу хүрээ, Амарбаясгалант хийд, Их хүрээ, Дуутын хүрээ, Ярууний хүрээ, Шар сүм, Ялгуусан гэгээний хүрээ, Хамба хутагтын хүрээ, Заяын хүрээ, Эрдэнэ Зуу, Баруун хүрээ, Дамбадаржaa хийд, Зүүн Чойр, Еэгүзэр хутагтын хүрээ, Сэцэн ханы хүрээ, Хэрлэнгийн Зүүн хүрээ, Хүүхэн хутагтын хүрээ лав дацантай байсан.

Хүрээ хийдийн ойрхон эсвэл хол байх уул хайрханы овоо нь ялангуяа жилийн тахилгатай байсан. Рашиан, Мааньт хад ч байсан. Цөөхөн хийд нь хадны зурагтай байв (жишээлбэл Заяын хүрээ).

Хүрээ хийдүүдийн лам нарын тоог бодож үзвэл дансанд орсон лам нар байсан боловч зарим нь хүрээн дотор, зарим нь хөдөө амьдарч дүйцэн өдрүүдээр ирдэг байв. Жишээ нь Заяын хүрээнд 1500 орчим лам нар амьдардаг байсан ба жилийн

²⁷ Позднеев хятадын тойпуу буюу хөх тоосго хийх бааюуг бас дурдахгүй байна.

· дүйцэн өдрийн 4000 орчим лам нар ирж хурал хурсан байна (Mongolia, 1-р боть, 274-р х.). Позднеев Ховдын Шар сүмийг хараад сүмийн тухай ингэж бичсэн “лам нар хөдөө гэртээ харив. Шар сүмд жилд гурван удаа хурал хурдаг. Энэ нь Монголын хөдөөний дугануудын ерөнхий байдал юм.” Манжийн үеийн дараа харин Богд хаант улсын үед (1911-1921) сүм хийдүүдийн лам нарын тоо эрс өсжээ.

Жилийн дүйцэн өдрийн заримыг дурдвал, том хүрээ хийдүүдэд Цам хайрлах, Майдар эргэх, Ганжуур эргэх, Хайлэн, Бурхан багшийн дүйцэн өдрийд, Зулын 25, Чоймпрэл жунааг хурдаг байв.

Энгийн хүмүүс хүрээ хийддээ амьдардаггүй учраас лам нар сахил сахих нь их чанга байв. Ялангуяа Зүүн Чойр ба Зүүн Хүрээ нь борчууд, хамжлагат ард суух газруудаас хол байсан.

Позднеев зоч лүүжинч болон хөдөө нямба хийсэн лам нарыг аялалын тэмдэглэлдээ дурдаагүй байна. Харин тэрээр нэг удаа Улиастайн нэг хятад наймаачинд самар зарах зорилготой гурван тэмээ ачаатай яваа Луу гүний хошууны (odoogийн Архангай аймаг, Батцэнгэл сум) нэг ламтай уулзаж дан ганц сүм хийдэд завилан суугаад байдаггүй харин амьдралын их туршлагатай хүн байсныг харуулжээ (Mongolia, 1-р боть, 239-р х.).

Позднеев мөн хүн гаргаж нутаглуулдаг хэдэн газрыг тэмдэглэсэн байна (Mongolia, 1-р боть, 275-р х.). Ер нь хутагт хувилгаадын шарилыг Гүдэн сүм буюу Шарилын сүмд занданшуулан залдаг байсан бол бусад хүмүүсийн шарилыг ил тавьдаг байв. Позднеев Цэцэн ханы бунханг тэмдэглэж (Mongolia, 2-р боть, 289-р х.) хаан ноёдын оршуулгыг ямар байсныг харуулжээ. Позднеев хятад хүний оршуулгын ёс заншилыг бас дэлгэрэнгүй тайлбарлажээ.

Зарим хүрээ хийд нь номын сантай байсан боловч (жишээ нь Заяын хүрээ), лам нар хурал хурахад номоо өөрсдөө авч ирдэг байжээ. Позднеев ном барлах барханы газыг хөдөөний хүрээ хийдүүдээр явж байхдаа үзээгүй байна.

Сонирхолтой баримт гэвэл Яруугийн хүрээ нь урьд нь нэг цэргийн хуарангийн хашаанд анх байгуулсныг Позднеев бичжээ. Ялгусан гэгээн анх байгуулаад дараа нь зүүнхойшоо нууж уг хүрээ Өвгөн хүрээ гэж нэртэй болжээ. Мөн Позднеев нэг муудаж, эвдэрсэн хийдийн талаар (Mongolia, 1-р боть, 134-р х., одоо Баянхонгор аймаг, Ламын гэгээний хүрээний ойрхон) Номон ханы хуучин хийд гэж бичжээ. Энэ мэт зарим хүрээ нүүдэлж, байршилаа сольж байсныг бас харуулж байна.

Позднеевын "Religion" хэмээх номонд лам нарын сахил (гэнэн, гэцэл, гэлэн), зэрэг дэв (гэвш, гавж, аграмба, маарамба, зурхайч, гэх мэт), цол хэргэм (хамба, цорж, ловон, шунлайв, гэсгүй, гэх мэт), захиргааны хэргээмийн тухай (даамал, дэмч, нярав) уншиж болно. Жасын үйл ажиллагааг дурдвал (жас, Тө. spyi-sa) том хийдүүдийн дуган бүгд нь жастай байсан. Гол жас нь бас их жас гэдэг нэртэй байсан. Эдгээр нь тухайн дуганд засвар хийсэн эсэх, лам нарын манж цав, хурлын зохион байгуулалт ямар байсан, малын тоог хэр өөрчлөгдсөн эсэхийг тэмдэглэх үүрэгтэй байв.

Позднеев хүмүүс зөвхөн шашин шүтлэгийн нөлөөгөөр дан ганц лам болоогүй харин бага сага хөрөнгийн үүсвэр олж, цалин авч байсан болохоор мөн сүм хийдийн амьдрал сонирхолтой байсан болохоор лам болцгоож байсан гэж тэмдэглэжээ.

Хүрээ хийдүүдийн өв соёл

Позднеевын номноос Монголын хүрээ хийдүүдийн ерөнхий байдал ямар байсныг харж болно. Богд хаант Монгол улсын үед (1911-1921) уг хурлын газрууд нь хөгжжиг Монголын түүхэн дэх Буддын шашны "Алтан үе" байсны дараа Социализмын үеийн дараалт эхэлсэн билээ. Энэ үед хүрээ хийдийг хомроглон олноор устгасан

учраас Позднеевын тэмдэглэл ба авсан фото зургууд нь Монголын түүхийн үнэт ховор баримтууд болж өгнө.

Позднеевын үзэж, тэмдэглэсэн хүрээ хийдүүдээс зарим нь л үлдсэн. Зарим үлдсэнг нь социализмын үед нэгдэлийн агуулах, контор болгон ашиглаж аль эсвэл бригад болгон ашиглаж байв (Баруун хүрээ, Заян хүрээ, Өндөр Майдарын хийд гэх мэт). 1990 оноос хойш дахин засварлан сэргээгдэж сүсэгтэн олонд дахин үүд хаалгаа нээх болжээ (Эрдэнэ Зуу, Амарбаясгалант, Баруун хүрээ, Заян хүрээ). Мөн зарим туйран дээр шинэ дуган баригдаж, ашиглалтанд орсон байна (Хөгнө тарни хийд, Егүзэр хутагтын хийд), зарим дахин сэргээсэн дуган нь тал хээр газарт, хүн багатайн улмаас үйл ажиллагаа явуулж чадахгүй тул сумын төв нүүж нүүжээ (Далай вангийн хүрээ, Зүүн Чойр гэх мэт). Жижиг хурлын газруудаас ялангуяа гэрийн хурал буюу модон дугануудаас олдвор үлдээгүй (зарим Буухиа өртөө). Бусад том, жижиг хийдүүдээс ямар нэг суурь, туйр, тоосго, чулуу үлдجээ. Хэдхэн түүхэн газраас (жишээ нь Зуугийн ламын сүм, Зүүн Чойр) үлдэж хоцорсон олон янзын гоё хээ угалзтай тоосго, дээврийн чимэглэлийг одоо ч гэсэн харж болох ажээ. Позднеевын үзсэн, очсон сүм хийдүүдийн заримд мөргөлийн сүм, гэрэлт хөшөө, суврага бүтээгдсэн байх буюу хадагтай чулуу нь уг түүхэн газрын соёлын өвийг тэмдэглэн байжээ (жишээ нь Зүүн Чойр, Ялгусан хутагтын хүрээ). Олон газарт хүмүүсийн хэрэглэж байсан төмөр хайч, тогооны хэлтэрхийнүүд үлджээ (Дуутын хүрээ) Монгол дахь бүх хүрээ хийдүүдийн туйрыг харьцуулвал Хэрлэнгийн Зүүн хүрээ, Ялгусан гэгээний хүрээгээс маш цөөн дурсгал үлджээ. Учир нь тал газарт баригдаж, ихэвчлэн модон дуган байсан болохоор.

Сүм хийдээс үлдсэн бурхан шүтээнийг сурвалжилвал одоо байгаа сүм хийдэд ч тэр, музейд ч тэр хувь хүмүүс цөөн тооны шүтээн үлдсэн байна. Тэр шүтээнүүд 1937-38 онд далд нуугдаж байгаад 1990-өөд онд ил гарсан.²⁸

Монголын Үндэсний Түүхийн Архивд ба бусад архивуудад дээр дурдсан Позднеевын очиж үзсэн 47 сүм хийдийн талаар цөөн тооны баримт хадгалагдаж байна. Харин Кино Архив ба ШУА-ын гэрэл зургын архивт Позднеевын үзсэн 8-10 хийдүүдийн зургын цуглуулага бий.²⁹ Хөдөөний хөгшчүүл Позднеевын тэмдэглэсэн тэдгээр сүм хийдийн тухай лавлаж асуувал зарим зүйлийг тодруулж өгөх боломжтой юм. Мөн эрдэмтэн, судлаач нар болон хийдийн лам нар тэрхүү дахин сэргээгдэж, ашиглалтанд орсон өөрсдийнхөө хийдийн түүхийг, Позднеевын 1892-1893 оны тэмдэглэлээс тухайн үеийн байр байдлыг тодруулж мэдэх боломжтой. Ингээд бодохоор Позднеевыг урьд цагийн болон орчин үеийн Буддын шашны түүхийг холбогч “элч” гэж хэлмээр.

Ном зүй

- Войтов, В., Тихменёва-Позднеева, Н., Алексей Матвеевич Позднеев и его Восточная коллекция. Самара 2001
- Дашбадрах, Д., Монголын хутагтуудын намтрын ойллого (XVII-XX зуун). Улаанбаатар 2004
- Гантуяа, М., Шашны ёслол буюу хурал ном. Лам нарын сэтгүүл 1. Улаанбаатар 2010,

²⁸ Позднеевын Азид хийсэн аялалын хүрээнд цуглуулсан бурхан шүтээнүүдийн жагсаалт ба архивын баримтууд нь Войтов, В., Тихменёва-Позднеева, Н., Алексей Матвеевич Позднеев и его Восточная коллекция. Самара 2001.

²⁹ Хүрээ хийдүүдийн уран барилга, хуучин гэрэл зураг олон номонд гарсан. Жишээ нь Шепетильников, Н. М., Архитектура Монголии. Москва 1960; Майдар, Д., Монголын архитектур ба хот байгуулалт. Улсын Хэвлэлийн Газар, Улаанбаатар 1972; Цүлтэм, Н., Mongolian architecture. Улаанбаатар 1988.

178-183-р х.

- Лааган, Б., Халхын тамга бүхий хутагтуудын товчис. Улаанбаатар 2004
- Майдар, Д., Монголын хот тосгоны гурван зураг. Улаанбаатар 1970
- Майдар, Д., Монголын архитектур ба хот байгуулалт. Улаанбаатар 1972
- Majer Zs., Monasteries in the Mongolian Landscape Once and Today. ESCAS XI Conference 2009, Studying Central Asia: On Quest for the New Paths and Concepts? CD publication. Central European University. Budapest 2009
- Majer Zs., Teleki K., On the Current Condition of 190 Old and Present-Day Monastic Sites in the Mongolian Countryside, Zentralasiatische Studien, Bonn 2011, 93-140-р х.
- Позднеев, А. М., Города северной Монголии. Санкт-Петербург 1887, 1980
- Позднеев, А. М., Монголия и Монголи. Т. 1-2. Санкт-Петербург 1896, 1898
- Позднеев, А. М., Монгольская летопись “Эрдэнийн эрихэ” с пояснениями, заключающими в себе материалы по истории Халхи 1636-1736. Санкт-Петербург, 1883
- Позднеев, А. М., Очерки быта буддийских монастырей и буддийского духовенства в Монголии, Санкт-Петербург 1887, 1993
- Позднеев, А. М., Ургинские хуухты. Исторический очерк их прошлого и современного быта. Travaux de la Troisième Session du Congrès International des Orientalistes. Санкт-Петербург 1880, 1980
- Позднеев, А. М. (эмхт.), Bojda Fibñdamba qutuþtu-yin Erdeni Tuu-du Talaraysan tuyuñi. Санкт-Петербург 1900
- Pozdneyev, A. M., Religion and Ritual in Society: Lamaist Buddhism in late 19th-century Mongolia. ed.: Krueger, J.R. The Mongolia Society. Bloomington 1978
- Pozdneyev, A. M., Mongolia and the Mongols, edited by Krueger, J. R., translated by Shaw, J. R. and Plank, D., Bloomington, Indiana University 1971
- Ринчен, Б., Монгол ард улсын угсаатны судлал, хэлний шинжлэлийн атлас. Улаанбаатар 1979
- Шепетильников, Н. М., Архитектура Монголии. Москва 1960
- Сономдагва, С., Манжийн захиргаанд байсан үеийн ар монголын засаг захиргааны зохион байгуулалт (1691-1911), Улаанбаатар 1961
- Teleki K., Building on ruins, memories and persistence: Revival and survival of Buddhism in the countryside, In: Silk Road 7, Seattle 2009, pp. 64-73. (also http://www.silkroadfoundation.org/newsletter/vol7/srjournal_v7.pdf)
- Teleki K., Monasteries and Temples of Bogdiin Khüree. Mongolian Academy of Sciences. Department of History. Ulaanbaatar 2012
- Teleki, K. Monastic Sites visited by A. M. Pozdneev during his Second Trip to Mongolia (1892-1893). Acta Orientalia Academiae Scientiarum Hung. Vol. 67 (3), 337-361. Budapest 2014. (<http://akademiai.com/doi/abs/10.1556/AOrient.67.2014.3.7?journalCode=062>, <http://real.mtak.hu/23763>)
- Tsyltem, N., Mongolian architecture. Ulaanbaatar 1988
- Цэдэндамба, С. — Лхагва, Л. — Сонинбаяр, Ш. — Лувсанбалдан, Э. — Отгонбаатар, Р. — Амгалан, Н. (эмхт.). Монголын сүм хийдийн түүхэн товчоон. Улаанбаатар 2009
- Эрдэнэбүлэг, Б. (эмхт.), Монголын сүм хийдийн түүхээс... Улаанбаатар 2012
- Янжинсүрэн, С., Монгол судлаач Позднеевын тухай цөөн үг. Лам нарын сэтгүүл 1. Улаанбаатар 2010, 175-177-р х.
- <http://www.mongoliantemples.org>